**БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА** ........1
**БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ** ...... 18
2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ........ 19
2.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ........ 25
2.3. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ........ 28
2.4. Амьтан, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ........ 37
2.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ........38
**БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ** ........ 40
**БҮЛЭГ 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ** ........ 40
**БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ** ........ 40
**БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ** ... 40
**БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ** ..... 40
7.1. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ........ 41
7.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх бэлтгэл, гал унтраах хэрэгслийг шалгах ........ 42
7.3. Ажилчдыг зориулалтын хувцас хэрэгсэл, хошуувч, малгайгаар хангах ........ 43
**БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ 45
8.1. Хог хаягдлын ангилан ялгалт, Сумын ТҮК-ээр тээвэрлүүлэх, ........ 46
8.2. Төслийн талбайд орчинд хогийн сав байрлуулах, ........ 50
8.3. Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах эрх бүхий мэргэжлийн компанитай байгуулсан гэрээг тогтмол сунгаж ажиллах ........ 51
**БҮЛЭГ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** .. 57
**БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ** ........ 60
10.1. Усны чанарын судалгаа ........ 61
10.2. Хөрс, хөрсөн бүрхэвчийн шинжилгээ, судалгаа ........ 62
10.3. Агаарын чанарын шинжилгээ, судалгаа ........ 67
10.4. Хаягдал усны шинжилгээ ........ 70
**БҮЛЭГ 11. АЙМАГ, СУМ ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТЫН АЖИЛ, НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ** ........72
**ХАВСРАЛТ БҮЛЭГ 12** ........81
12.1. Тусгай зөвшөөрөл, баримт бичиг
12.2. Гэрээ
12.3. Шинжилгээний дүн

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн ерөнхий мэдээлэл**

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэсний дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, баганад мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “хамааралгүй” гэж бөглөнө.

Хүснэгт. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|---|---|---|
| 1.1 | Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэр | “Бласт” ХХК |
| | Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн | 9011125047 |
| | Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны | Тэсрэх материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, импортлох, худалдаалах |
| | Аж ахуй нэгжийн харъяаллын хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө- 13,3 дугаар давхар |
| | Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг | Гүйцэтгэх захирал А.Тэмүүлин Холбоо барих утас: 99112528 |
| | Хариуцсан мэргэжилтэн, нэр, утас, цахим шуудангийн хаяг | Байгаль орчны ажилтан Т.Эрдэнэбат Холбоо барих утас: 90002470 |
| 1.2 | 1.Төслийн нэр | “Таван толгой” салбар |
| | 2.Төслийн нэр харъяаллын байршил | Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан овоо баг |
| | 3.Төслийн ангилал | Үйлдвэр |
| | Төсөл эхэлсэн огноо | 2009 |
| | ТЭЗҮ батлагдсан огноо | 2018 он |
| | Ажилчдын тоо | 1 ээлжинд 72 ажилтантай нийт 144 |
| | Тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэрийн хүчин чадал | 120тн/хоногт |

# ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний “Бласт”ХХК нь үйлдвэрлэлийн тэсрэх материалын хангамж, тэсрэх бодисын үйлдвэрлэл, тэсрэх материалын хадгалалт, тээвэрлэлт, тэсэлгээний ажлын үйлчилгээ эрхэлдэг бөгөөд 2001 онд байгуулагдсанаасаа хойш 21 жил тасралтгүй, эрчимтэй явуулж байгаа үндэсний компани юм. “Бласт” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын Таван толгой” салбар нь 2009 онд байгуулагдсан өнөөг хүртэл үйл ажиллагааа явуулж байна.

**Тэсрэх бодис үйлдвэрлэлийн ерөнхий ойлголт**

*Задгай эмульсийн тэсрэх бодис:*

Үл холилдох хоёр шингэн нэг нь нөгөөдөө жигд тархсан систем юм. Усан ба тосон уусмалын нэгдэл бүхий усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодис нь гадаад байдлаараа зуурмаг, шингэн төлөвт байх ба тэсрэлтийн чадал болон бусад үзүүлэлт, хэрэглэх нөхцөл, хадгалалт, тээврлэлтийн үеийн аюулгүй ажиллагааны нэгдүгээр ангилалд хамаарна.

*Энгийн найрлагатай тэсрэх бодис:*

Энгийн найрлагатай тэсрэх бодис /цаашид ANFO гэх/ нь сүвэрхэг аммиакийн шүү ба шатах хольцоос тогтсон тэсэлгээнд зориулсан өртөг багатай тэсрэх бодис юм. Хэрэглэгчийн хүсэлтийн дагуу /ANFO/-ыг зориулалтын холигч цэнэглэгч авто машинаар тэсэлгээний талбайд бэлтгэнэ.

*Энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис:*

Энгийн тэсрэх бодисын хүчийг нэмэгдүүлэх зорилгоор энгийн тэсрэх бодисыг хольж энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис болгодог. Хольц нь ANFO-ны орцын хувиас хамааран 2 төрөл байна. ANFO нь 50-иас бага хувиар орвол энгийн тэсрэх бодисын хольц бүхий эмульсийн тэсрэх бодис /BLEND/ юм. ANFO нь 50-иас их хувиар орвол хүнд анфо буюу /Heavy ANFO/ болно. Дээрх 2 төрлийн хольцыг үйлдвэр болон тусгай зориулалтын цооног цэнэглэгч авто машинд бэлтгэж, үйлдвэрлэнэ.

**Үйлдвэр цогцолборын барилга байгууламж:**

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын тэсрэх бодисын үйлдвэрийн барилга байгууламжийн төлөвлөгөөг үйлдвэрийн хүчин чадал, хэрэгцээ болон үйлдвэрийн аюулгүйн зай талбайн хэмжээнд тулгуурлан боловсруулсан. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрт доорх барилга байгууламжууд байх бөгөөд нийт 4.47а талбайг хамарна. Цогцолборын агуулахын хашаанд түүхий эд, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалттай 20 тн-ын багтаамжтай, доторлогоо болон агааржуулах цонх, хоолой гаргаж, халалт, хур тунадасаас хамгаалж давхар дээвэр

хийсэн 18 төмөр чингэлэгийг хамгаалалтын далан дунд байрлуулсан. Аж ахуйн агуулах нь 20 тн-ын багтаамжтай, 2 чингэлэгээс бүрдэнэ.

## ТАЛБАЙН БАЙРШИЛ

Төслийн талбайн байршил, орчны төлөв байдал Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 600 км, Даланзадгад хотоос зүүн хойш 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун урд зүгт 4.5 км зайд байрлана.

*Хүснэгт. 2.Талбайн булангын цэгүүдийн газарзүйн солбилцолуудыг хүснэгтээр үзүүлэв.*

| № | X | Y |
|---|---|---|
| **1** | 4841049.75 | **542523.52** |
| **2** | 4841150.94 | **542647.55** |
| **3** | 4841054.05 | **542726.60** |
| **4** | **4840952.86** | **542602.58** |




Зураг 1 Төслийн байршил, Google earth санрсын зургаас харагдах байдал







*." Бласт " ХХК-ийн үйлдвэр агуулах*

*Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр*





*. Химийн бодисын агуулах*

*Туухий эд, тэсрэх материалын агуулах*





*Уурын зуух*

*.Үйлдвэр агуулах*





*Ажитчдын амрах байр*

*Цахилгааны эх үүсвэр*

## ДЭД БҮТЭЦ

**Дулаан хангамж:** Үйлдвэрийн байр, харуулын байрыг уурын зуухаар халаана.

**Зам харилцаа:** Улаанбаатар хотоос Цогтцэций сум хүрэх хатуу хучилттай авто замаар холбогдсон.

**Харилцаа холбоо:** Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр нь хүн ам төвлөрсөн сумын төвөөс 6.5 км зайд байрлах ба үүрэн телефоны бүх сүлжээ ашиглах боломжтой.

**Хатуу хог хаягдал:** “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу хур хог хаягдал үүсгэхгүйгээр тогтмол тээвэрлүүлэн сумын нэгдсэн хогийн цэг рүү татан зайлуулж байна.

**Цэвэр ус:** Ундны усны хэрэглээг 0,5 литрийн савалгаатай цэвэр усаар, үйлдвэр болон ахуйн хэрэглээний усыг өөрсдийн өрөмдлөг худгаас хангаж байна.

**Аюултай хог хаягдал:** “Түмэн эгшиг” байгууллагатай хамтран, үйлдвэрийн бүсээс гарсан хог хаягдлаа нийлүүлэн ажилладаг.

**Усан хангамж:**

**Түмэн эгшиг байгууллагатай хамтран үйлдвэрийн бүсээс гарсан хог хаягдлаа нийлүүэл**

Худаг өргөтгөлийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк

| Худаг | Байршил | Гүн | Ундарга л/сек | Тоолуур | Гаргасан он |
|---|---|---|---|---|---|
| Бласт-ТТ | 43°42´14´´N<br>105°31´48´´E | 120 | 0.8 | LXSG-50 | 2010 |






Зураг 2 Үйлдвэрийн худгийн байгууламж

**Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлийн тодорхойлт**

Төслийн сөрөг нөлөөллийн тодорхойлолт “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн үйл ажиллагааны үед байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх технологийн үе шатуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Түүхий эдийг тээвэрлэх авч ирэх;
2. Тэсрэх бодисыг үйлдвэрлэх;
3. Уурхайн талбай руу тээвэрлэх;
4. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал;
5. Төслийн талбайн эргэн тойронд шинээр шороон зам бий болгох;
6. Технологийн болон ахуйн гаралтай хог хаягдлын цэг-талбай;
7. Уурын зуух, цахилгаан үүсгүүр ажиллуулах;

Тус төслийн үйл ажиллагаа нь 4.47 га талбайд явагдана. Тухайн талбай дотор хөрс, ургамлан бүрхэвч эвдрэлд өртөх болно. Төслийн үйл ажиллагаанаас экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг энэ хэсэгт хамруулсан.

Экосистемийн өөрчлөлт

“Тэсрэх бодисын хольцын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн голлох барилга байгууламжууд нь геологийн тогтоцыг эвдэж, экосистемийн бүрэлдэхүүн хэсэгүүдэд хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн үйлдвэрлэл ба унд-ахуйн хэрэгцээнд газрын доорх усны нөөц баялгийг ашиглана. Төслийн үйл ажиллагааны явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд бус нөлөөлөлд хамаарна. Төслийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, ургамлан нөмрөг, газар, газрын доорхи усны нөөцөд шууд дунд зэрэг сөргөөр нөлөөлнө.

Байгаль орчны чанарын өөрчлөлт

Шатах тослох материал, хог хаягдал, химийн бодис зэрэгтэй холбоотойгоор хөрс, ургамал бохирдох эрсдэлтэй байна.

**Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор**

Байгалийн тогтоц буюу газрын гадаргын хэлбэршилд хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй бөгөөд хамгаалалтын далан овоолго, үерийн шуудуу зэрэг үүсэх бөгөөд энэ тухайн 4.86 га талбайн байгалийн унаган дүр төрх, ландшафтыг өөрчлөлтөд оруулах боловч нөхөн сэргээлтийг бүрэн хийснээр сөрөг нөлөөллийг арилгах боломжтой.

**Нийгэм, эдийн засаг**

Тус төслийн үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулахаас гадна 30-35 хүнийг ажлын байраар хангах ба ажлын байр нэмэгдэх нь тэдний амьжиргаанд тус нэмэр болж буй сайн талтай юм. Эдгээр нь шууд бөгөөд богино хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

**Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ**

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас буюу үйлдвэрт хэрэглэгдэж буй химийн бодисууд ямар нэгэн байдлаар газрын гадарга руу алдагдсанаар газрын хэвлий болон түүний гадаргыг бохирдуулж болзошгүй;
- Хүний буруутай үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны дүрмийг чанд баримтлан ажиллаагүйн улмаас химийн бодисын агуулах, тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодисын агуулах зэрэг объектуудад осол-аюул гарснаар газрын гадаргад ноцтой аюул, гамшиг, бохирдол үүсгэж болзошгүй;
- Байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн бодис, тэсрэх бодис газрын гадарга, хөрсөнд хаягдаж болзошгүй;
- Байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн бодисын агуулах, тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодисын агуулахад осол-аваарь гарснаар газрын гадаргад ноцтой аюул, гамшиг, бохирдол үүсгэж болзошгүй
- Тэсрэх бодисын үйлдвэрийн машин, техникийн ашигласан тос алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй;
- Химийн бодис болон түүний сав баглаа боодлын хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.
- Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.

Агаар орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Тэсрэх бодисын үйлдвэрт хэрэглэгдэх химийн бодисуудаас агаарын чанарт цөөн хэдэн хүчин зүйлсээр болзошгүй нөлөөлөл үзүүлэхээр байна. Энэ нь химийн бодисуудыг ашиглах, тээвэрлэх, хадгалах болон тэдгээрийн хаягдлыг устгах үед гадаад орчны болон ажлын байрны агаарын чанар, найрлагыг өөрчилж болзошгүй байдлаар тодорхойлогдно.

Төслөөс тухайн нутгийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай,

дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдаж, салхиар тарах зэргээр чанар найрлагыг өөрчлөх;

- Химийн бодис, түүний сав баглаа боодлын хаягдлыг шатаах аргаар устгах үед хортой хий ялгаран агаарын чанарт сөргөөр нөлөөлөх;
- Хог хаягдлын зохисгүй хадгалалт, зохион байгуулалтаас агаар орчин бохирдох;
- Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах хорт хийн дэгдэлт агаарын чанарт нөлөөлөх зэрэг болно;
- Төслийн бүс нутгийн уур амьсгалын эрс тэс байдал нь химийн бодисын хадгалалтын горимыг алдагдуулах нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.

Химийн бодисуудыг хадгалах агуулах, болон орчны үзүүлэлтүүдийн горим алдагдсанаас дэгдэмхий ууршимтгай бодисуудын физик төлөв, найрлагыг өөрчлөн уурших, исэлдэх улмаар агаарт дэгдэн гарч салхиар дамжин орчны агаарын чанар найрлагыг өөрчлөнө. Агаарын найрлагад ийм байдлаар нөлөөлөх бодисуудад, халалтаар ууршиж хортой хий ялгаруулдаг доорхи төрлийн бодисууд орно. Үүнд:

- Найрлагадаа ханасан болон ханаагүй нүүрсустөрөгч агуулсан бүх төрлийн нефть бүтээгдэхүүний гаралтай органик тос, тосолгооны материалууд, автомашины түлш- Хөдөлгүүр, дамжуулах эд ангийн тос, гидрийн шингэн, тосол, товуд;
- Давсны хүчил, цууны хүчил зэрэг хорт хий ялгаруулдаг органик болон органик биш хүчлүүд зэрэг болно.

**Гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ**
Төслөөс тухайн нутгийн газрын доорх усанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны үед хөрсний болон газрын доорх усны нөөц, түүний чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд нь хаягдал бохир ус болон, шатах, тослох материалын хаягдлаар бохирдож болзошгүй байна;
- Олон машин механизмын зүй бус ашиглалтаас бензин, дизель болон бусад хорт бодис гоожих эсвэл алдагдсан нөхцөлд хөрс, орчмын ургамлын бүрхэвчид сөргөөр нөлөөлж улмаар хөрсөнд нэвчин гүний усыг бохирдуулах болзошгүй;
- Төслийн талбай орчимд хэд хэдэн хуурай сайр байгаа нөхцөлд аадар борооны үед усжин үер буух нөхцөлтэй;
- Төслийн үйл ажиллагааны газрын доорх усны хэрэглээний улмаас нутгийн иргэдийн гар худаг болон гүний худгийн усын түвшин доошилж, ундарга багасж болзошгүй;
- Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг

зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас үүдэн газрын доорх ус бохирдож болзошгүй;
- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор гадаргын болон газрын доорх ус бохирдож болзошгүй.

**Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ**

Тус төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь химийн бодис, шатах тослох материал, тос тослогооны материал асгарах, алдагдах болзошгүй нөлөөлөл байна. Хөрсөнд химийн бодис, шатах тослох материал алдагдсанаар ургамал, амьтанд дам нөлөөлөл үзүүлэх болно. Өнөөгийн байдлаар хөрсний эвдрэл нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр бий болж байна. Ялангуяа олон салаа зам гарсанаас бэлчээрийн талбай доройтож ургамлын бүрхэвч байхгүй болж байгаа юм. Ялзмагт өнгөн хөрс алга болох нь ойт хээрийн хэврэг, эмзэг экосистемтэй бүс нутагт ургамал амьтаны амьдрах нөхцөл алдагдах үндсэн шалтгаан болдог. Мөн зам талбайн хөрс нэлэнхүйдээ эвдрэлд орж хөрсний бүтцэд өөрчлөлт орно. Барилгын ажлын явцад салхи, шуурганы нөлөөгөөр өнгөн хөрсний тодорхой хэсэг алдагдах нөхцөлтэй. Дээрхээс гадна:

- Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас үүдэн хөрс бохирдож болзошгүй;
- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор хөрс бохирдож болзошгүй;
- Химийн бодис болон ахуйн гаралтай хог хаягдлын зохисгүй хадгалалт, зохион байгуулалтаас хөрс бохирдох;
- Болзошгүй галын аюул, осол ааварийн үед гарах үнсний дэгдэлт, химийн бодисын алдагдлаас хөрс бохирдож болзошгүй зэрэг болно.

Ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Үйлдвэр орчмын ургамлан нөмрөг зарим төрлийн осол аваар, техникийн аюулгүйн ажиллагааны алдаанаас шалтгаалан шууд болон дам сөрөг нөлөөлөлд өртөх магадлал байна. Үүнд:

- Тээвэрлэлтийн болон хаягдал устгалын үеийн осол ааварийн үед химийн бодис болон техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлж, бохирдуулах;
- Гал, ослын үед дэгдсэн хорт утаа хур тунадасаар дамжин ургамалжилтад нөлөөлөл

үзүүлж, тэжээлээр дамжин мал, амьтад хордох;

- Химийн бодис болон шатах-тослох материалаар хөрс бохирдсоноос шалтгаалж ургамал ургах нөхцөл буурах;
- Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас үүдэн ургамалан бүрхэвч бохирдож болзошгүй;
- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас болон байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор ургамалан бүрхэвч бохирдож болзошгүй;
- Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах үнсний дэгдэлт, химийн бодисын алдагдлаас ургамалан бүрхэвч бохирдож болзошгүй зэрэг болно;

**Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ**

Төслөөс амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьдад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;
- Химийн бодис асгарах, алдагдах, химийн бодисын хаягдал, бодисын сав баглаа боодлыг зохих журмын дагуу устгалгүй, ил задгай хаяснаас амьтад хордож болзошгүй;
- Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсах, байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн улмаас химийн хорт бодисоор амьтад хордож болзошгүй;
- Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах үнсний дэгдэлт, химийн бодисын алдагдлаас амьтад хордож болзошгүй зэрэг болно.

**Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ**

Тус үйлдвэр орчмын нутаг дэвсгэрт нутагладаг малчин өрхүүд, болон ажилчид болзошгүй эрсдэлд өртөх нөлөөллийг авч үзвэл:

- Төслийн үйл ажиллагааны горим алдагдсанаас ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд нь аюул учрах;
- Төслийн аюулгүйн ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд аюул учрах зэрэг болно;
- Төслийн дотоод ба гадаад тээврлэлтийн буруу зохицуулалт, үйл ажиллагаанаас ослын түвшин нэмэгдэх.

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосонцор болон хийнүүд нь салхиар зөөгдөж

тухайн газар орчмын агаарыг бохирдуулахаас гадна орон нутгийн байгаль орчин, хүн, амьтанд зохисгүй нөлөөлдөг. Үйлдвэрийн барилгын ажлын үед болон үйлдвэрийн үйл ажиллагааны үед машин механизмуудын хөдөлгүүрээс ялгарч буй дутуу шаталт, хатуу шингэн хог хаягдлын ялзралын дүнд үүсэх хорт хийнүүд нь агаарын бохирдлыг үүсгэгч шууд болон дам хүчин зүйлс болж болдог.

“Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үндсэн 3 нөлөөлөл байна. Үүнд:

- Төсөлд ашиглагдаж байгаа машин механизм, дизель станциас ялгарах бохирдуулагч бодисууд;
- Төслийн талбай болох химийн бодисын агуулахуудын хамгаалалтын далангаас тоос дэгдэж агаар орчинд тархана;
- Үйлдвэрийн түүхий эд болон бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд агаар мандалд гарах тоосны хэмжээ хуурайшлын үед нэмэгдэх, зөөгдөх;
- Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдал агаар орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

**Дуу чимээ, шуугиан**

Тухайн төслийн хувьд дуу чимээ, шуугийны бохирдлын 82-85 дб дууны даралт үзүүлдэг дизель цахилгаан үүсгүүр, техникийн засвар үйлчилгээ, гагнуурын ажил зэрэг нь тус тус хамаарна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед үүсэх шуугианы эрчим дунд зэрэг бөгөөд хугацааны хувьд тогтмол байна. Эх үүсвэрээс чимээ шуугиан нь ил задгай агаарт чөлөөтэй тархана.

Тооцооны дагуу дизель генераторын ажлаас үүсэх чимээ шуугианы аюулгүй түвшинд хүртэл буурах зай буюу АТНБ-ийн радиус өдрийн цагаар 55.5 м шөнийн цагаар 96.5 м, нэгэн зэрэг 3 төрлийн эх үүсвэр ажиллах үед уулын техникийн хөдөлгүүрээс үүсэх чимээ шуугианы АТНБ-ийн радиус өдрийн цагаар 43.0 м шөнийн цагаар 75.5 м тус тус байна.

**Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл**

“Бласт” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах”-ын талбай нь газрын гадаргын хувьд тэгш, хэрчигдэл, гуу жалга байхгүй цөлжүү хээрийн цайвар бор хөрстэй байна.

Төслийн талбайн жижиг ааparag толгод бүхий нугачаад хөндийд байрлах бөгөөд эдэлбэр газрын гадаргын хувьд тэгшилж зассан байна. Төслийн талбайн урд талаар Энержи Ресурс ХХК-ийн нүүрсний ил уурхай, овоолгууд хүрээлнэ.

“Бласт” ХХК нь төслийн талбайд энэхүү тайлангийн 3-р бүлэгт тодорхойлсон барилга байгууламжуудыг байгуулсан байна. Үүнд:

- Химийн бодисын агуулахууд (сендвичен барилга ба чингэлэгүүд);
- Үйлдвэр болон оффис, бусад байгууламжууд;
- Дизель түлшний агуулах (газарт булсан);
- Цементэн талбайнууд;
- Чингэлэгүүд
- Хамгаалалтын шороон далангууд;
- Хамгаалалтын шуудуу;
- Хогийн цэг;
- Туршилтын талбай;

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Бласт” ХХК-ийн тэсрэх бодисын агуулахын талбай нь сумын төвөөс баруун өмнө зүгт 3 км-т байршилтай, Нүүрс тээврийн хатуу хучилттай замын зүүн талд. Агуулахын талбай, түүний орчмын гадаргаар Сайргархаг Бор хөрс (сайр чулуутай), нам доор хөндийн хэсэгт Хужир мараалаг хөрс тус тус тархсан.

Хүснэгт. 3 *Хөрсний агрохимийн шинж чанар*

| Дээжний дугаар | Гүн, см | pHH$_2$O | Сульфат /SO4/ | Нитрат /NO3/ | Чийг | Ялзмаг | Хөдөлгөөнт, мг/100г |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | P$_2$O$_5$ |
| **Зүсэлт-1 уурын зуух орчим** | 0-25 | 8.87 | 54.1 | 40.7 | 0.70 | 1.74 | 11.2 |
| **Зүсэлт-2 Агуулах** | 0-25 | 9.07 | 221.4 | 230.7 | 0.78 | 1.98 | 10.3 |
| **Зүсэлт-3 Харуулын байр** | 0-25 | 8.41 | 156.8 | 142.6 | 0.63 | 1.42 | 5.3 |
| **Зүсэлт-4 Хогын цэг** | 0-25 | 8.21 | 751.6 | 142.6 | 0.71 | 1.52 | 4.04 |

Хөрсний органик бодисын агууламж 0.325% буюу ижил хэв шинжийн хөрсний түвшин (1%- бага) хэвийн. Хөрсний урвалын орчин дунд шүлтлэг (8.21-9.07), өнгөн үеэс карбонат илрээгүй, хялбар уусах давсны агуулга маш бага, давсжилтгүй (0.092 dS/m), хөдөлгөөнт элементүүд ижил хэв шинжийн хөрстэй харьцуулбал бага агууламжтай.

**Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл**

Төслийн талбайд хийсэн ургамлын судалгаагаар нийт 9 овог, 17 төрөлд хамаарах 23 зүйлийн ургамал бүртгэгдэв.

Хүснэгт. 4*Төслийн талбайд бүртгэгдсэн ургамлын жагсаалт*

| д/д | Латин нэр | Монгол нэр |
|---|---|---|
| | **I. Gramineae Juss. - Үетний овог** | |
| 1 | *Stipa gobica* | Говийн хялгана |
| 2 | *Cleistogenes songorica* | Зүүнгарын хазаар өвс |
| | **II. Liliaceae Juss. - Сараанын овог** | |
| 3 | *Asparagus gobicus* | Говийн хэрээн нүд |
| | **III. Polygonaceae - Тарны овог** | |
| 4 | *Rheum nanum* | Намхан гишүүнэ |
| | **VI. Chenopodiaceae Vent. - Луулийн овог** | |
| 5 | *Bassia dasyphylla* | Үслэг манан-хамхаг |
| 6 | *Corispermum mongolicum* | Монгол хамхуул |
| 7 | *Chenopodium album* | Цагаан лууль |
| 8 | *Echinopsilon divaricatum* | Дэрвэгэр мананхамхаг |
| 9 | *Halogeton glomeratus* | Баг хуш-хамхаг |
| 10 | *Salsola collina* | Толгодын бударгана |
| 11 | *Salsola pestifer* | Өргөст бударгана |
| **V. Rutaceae Juss. – Хүж өвсний овог** | | |
| 12 | *Haplophyllum dauricum* | Хүж өвс |
| | **VI. Leguminosae Juss. – Буурцагтан** | |
| 13 | *Caragana pygmeae* | Тарваган харгана |
| 14 | *Astragalus monophyllus* | Ортууз |
| | **VII. Zygophyllaceae - Хотирын овог** | |
| 15 | *Peganum nigellastrum* | Харлаг үмхий өвс |
| | **VIII. Labiatae - Уруул цэцэгтэн** | |
| 16 | *Lagochilus ilicifolius* | Ямаан ангалзуур |
| | **IX. Compositae Giseke. – Нийлмэл цэцэгтэн** | |
| 17 | *Artemisia pectinata* | Шүлхий шарилж |
| 18 | *Artemisia ruthifolia* | Шаргал шарилж |
| 19 | *Artemisia xerophytica* | Хуурайсаг шарилж |
| 20 | *Artemisia macrocephala* | Царван шарилж |
| 21 | *Artemisia xanthochroa* | Татанхай шаваг |
| 22 | *Artemisia scoparia* | Улаан шарилж |
| 23 | *Scorzonera pseudodivaricata* | Хуурамч дэрэвгэр хависгана |

**Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл**

Төслийн хамгаалалтын шороон далан, шуудуу байгуулах үйл ажиллагаа нь хөрсөнд амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавьжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчинг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ.

Төсөлд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон

хөхтөн амьтад төслийн талбай орчмоос дайжих, жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарна.

Ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг шувууд цуглаж болзошгүй.

Үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад нөлөөлнө.

Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан дуу чимээ, тоос гарах, усны нөөц багасах, бэлчээрийн доройтол болох зэрэг сөрөг үзүүлэлт гарснаар зэрлэг ан амьтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Зарим төрлийн шавьжийн амьдрах орчинг устгах;
- Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих;
- Төслийн зам тээврийн үйл ажиллагаанаас зарим амьтадын популяцын тусгаарлалт үүсэж, амьтадын нүүдэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлнэ;
- Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьдад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө

**Төслийн үйл ажиллагаанаас гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл**

**Гадаргын ус**

Төслийн талбай болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөхөөр гадаргын ус байхгүй болно.

**Газрын доорх ус**

“Бласт” ХХК-ийн Тавантолгой салбар нь 1 гүний худагтай байна. Тус худгаас төслийн нийт усны хэрэгцээг хангадаг байна

| Дээжний дугаар | Координат | | Уст цэгийн төрөл |
|---|---|---|---|
| 1 | 4839113,3 | 542506,5 | Гүний худаг |

Энэхүү уст цэгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, холимог бүлгийн, 2 р

төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү хатуу ус байна. Сорьцонд хуурай үлдэгдэл 952 мг/л, ерөнхий хатуулаг 16-экв/л мг/экв, pH 6.-82, исэлдэх чанар 13.12 мг/дм3 байна. Говь хээр бүсийн гүний эрдэс чулуулгийн геохими шинж чанараас шалтгаалан усны химийн үндсэн үзүүлэлтүд харилцан өөр байдаг Бүс нутгийн гүний эрдэс чулуулгийн геохими шинж чанараас шалтгаалан усны эрдэс найрлага өөр байдаг. Энэхүү дээжний үр дүнгээс харахад хатуулаг ихтэй **Cl, Ca, Mg** агууламж өндөртэй байна.

Хүснэгт. 5 Усны хими шинжилгээний дүн

| Шинжилсэн үзүүлэлтүүдийн Нэр хэмжих нэгж | Шаардлага | Шинжилгээний дүн |
|---|---|---|
| **ББЕТ** | 1 мл-т 100-с ихгүй | Нянгийн тоо |
| **Salmonella spp** | 25 мл-т илрэхгүй | Илрээгүй |
| **Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян/ ялтсан шүүлтүүр/** | 100 мл-т | Илрээгүй |
| **Аммони** | 1.5 мг/л | 0.03мг/л |
| **Кальци** | 100 мг/л | **191.382мг/л** |
| **Магни** | 30 мг/л | **84.152 мг/л** |
| **pH** | 6.5-8.5 | 6.82 |
| **Хатуулаг** | 7мг-экв/л | **16.5-экв/л** |
| **Хлорид** | 350мг/л | **400.529мг/л** |
| **Хуурай үлдэгдэл** | 1000мг/л | 952 мг/л |
| **Цахилгаан дамжуулах чанар** | 1мСм/см | **1.864м См/см** |
| **Зэс** | 1л-т 2мг/л | 0.01мг/л |

Тус төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн газрын доорх усанд дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Газрын доорх ус ашиглана, ус нөөцийн хомсдол үүснэ;
- Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис, бохир усны алдагдал, нэвчилтээс бага гүний уст үеүд бохирдох;
- Тус тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор нь унд-ахуйн хэрэгцээндээ жилд 814.5 м3, үйлдвэрлэлийн хэрэгцээндээ жилд 3040.8 м3 ус хэрэглэдэг байна. Жилд ойролцоогоор 3855.3 м3 ус хэрэглэдэг ;
- Үйлдвэр болон ажилчдын байр, душны бохирыг газар доор байрлуулсан 25 тн-ын багтаамжтай 2 ш битүүмжлэлтэй саванд түр байршуулж 5 тн даацтай бохирын машинаар соруулан орон нутгийн харьяа цэвэрлэх байгууламжид гэрээгээр нийлүүлүүлдэг.

**Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Тусгай хамгаалалттай газар гэж байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор тодорхой хэмжээний газар нутгийг улс болон орон нутгийн захиргааны хамгаалалтад авсныг хэлнэ. МУ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

1/ дархан цаазат газар;
2/ байгалийн цогцолборт газар;
3/ байгалийн нөөц газар (БНГ); 4/ дурсгалт газар.
Төслийн талбай нь улсын болон тусгай хамгаалалттай газар нутагт хамаарахгүй.
“Бласт” ХХК-ийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын “Тавантолгой” салбарын талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байрлана.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ**

“Бласт”ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Таван толгой дахь “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тухайн төслийн хэрэгжилтийн явцад авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Бласт” ХХК-ийн тэсрэх бодисын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилготой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлхээр зорино. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах;
- БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх;
- “Бласт”-ийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх;
- Сум орон нутгийн байгууллагатай байгаль орчин, нийгмийн хүрээнд хамтран ажиллах

**ХӨРӨНГӨ САНХҮҮ**

“Бласт”ХХК-ийн үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөөнд байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тусгаж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулдаг.

# БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах**

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад технологийн болон удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн БОНБНҮний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох хууль дүрэм журам стандартуудыг мөрдөн ажиллах юм.

1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

1.2 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

1.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

1.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

1.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

## 2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

### 2.1.1. Замаас үүсэх тоосжилтыг бууруулахад хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах

Үйлдвэрийн орчимд хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ, түүхий эд тээвэрлэх зам дагуу салаа зам үүсгэхээс сэргийлж чиглэл заасан тэмдэг байршуулан, авто зогсоолын хэсэгт хайрга чулуу дэвсэн, маршрутын бус салаа замаар зорчих хэсгийг хааж тоосжилт үүсэх, хөрс эвдрэхээс сэргийлэн ажиллаж байна.

Зураг 3.Тэмдэг тэмдэглэгээ байршуулалт




Зураг 4.Салаа замаар зорчих хэсгийг хаасан байдал



**2.1.2. Агаар дахь тоосжилтийг хэмжих шинжилгээ хийх.**

Өмнөговь аймгийн ЦУОШГ-тай хамтран үйлдвэр, уурын зуух, хогны цэг, үйлдвэрийн гадна зэрэг 4 цэгээс дээж авч, агаарын тоосонцрын хэмжилт хийлгэсэн.



Зураг 5. Агаарын чанарын хэмжилт



Зураг 6 Дотоод орчны агаарын хэмжилтийн багаж

Хүснэгт. 6 Агаар дахь тоосонцорын хэмжилтийн дүн

| № | Хэмжилт хийсэн цэг | Хүхэрлэг хий/SO2 | Азотын давхар исэл NO2 | PM 2.5 тоосонцор | PM 10 тоосонцор | Нийт тоос TSP 20минут |
|---|---|---|---|---|---|---|
| | | МКг/м3 | МКг/м3 | МКг/м3 | МКг/м3 | МКг/м3 |
| **1** | Оффис уурын зуух орчим | 4 | 9 | 17 | 41 | 89 |
| **2** | Агуулах орчим | 7 | 12 | 17 | 23 | 91 |
| **3** | Харуулын байр орчим | 9 | 19 | 54 | 67 | 112 |
| **4** | Хогны цэг | 3 | 7 | 21 | 49 | 63 |
| **Хүлцэх хэм хэмжээ MNS 4585:2006** | | **450** | **200** | **50** | **100** | **500** |

Үр дүнгээс харахад төслийн талбайд нарийн ширхэгт тоосонцрын агууламж 17мкг/м3 -54мкг/м3 хооронд, хамгийн өндөр утга нь харуулын байр орчим стандартаас 4 мкг/м3 хэмжээгээр илүү байна. Бусад цэгүүдэд агаарийн чанар стандарт утгад байна. Том ширхэгт тоосонцор болон Хүхэрлэг хий/SO2, Азотын давхар исэл NO2, бохирдуулагч бодисын хэмжээ хэмжилт хийсэн 4 цэгт стандартаас утгаас хэтрээгүй байна/

График 1. 2024 оны агаарын чанарын хэмжилт




График 2 Тоосонцорын 4 жилийн дундаж утга




Үр дүнгээс харахад нарийн ширхэгт PM 2.5 тоосонцорын агууламж 2022 онд 70мкг/м3 буюу стандартаас их байсан бол 2024 оны хэмжилтийн дүнгээр 27.2 /м3 буюу 2-2.5 дахин багасссан байна. Том ширхэгт тоосонцорын агууламж 45 мкг/м$^3$ MNS 4585:2006 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байа.



MNAS Accreditation system TL 08-10 MNS ISO/IEC 17025

Ус цаг уур орчны шинжилгээний төв
Байгаль орчны шинжилгээний
Лаборатори

Өмнөговь аймаг Даланзадгад сум 6-р баг
Утас/Факс: 70533648
E-mail хаяг umnugovi44373@gmail.com

ӨМНӨГОВЬ УЦУОШТ

Захиалагч: “ Блас” ХХК
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Цогтцэций сум Тэсрэх материалын агуулах
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Б.Янжин/ эрхлэгч
Сорьцын тоо хэмжээ: 4
Сорьцын төрөл: Орчны агаар
Сорьц авсан огноо: 2024.06.09
Лабораторид хүлээж авсан : 2024.06.10
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.06.10
Хэвлэсэн огноо: 2024.06.17
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН/ мкг/м3

| № | Хэмжилт хийсэн цэг | Хүхэрлэг хий/SO2 | Азотын давхар исэл NO2 | PM2.5 тоосонцор /20 минут | PM10 тоос/ 20 минут | Нийт тоос TSP 20 минут |
|---|---|---|---|---|---|---|
| | | Мкг/м3 | Мкг/м3 | Мкг/м3 | Мкг/м3 | Мкг/м3 |
| 1 | Оффис, уурын зуух орчим | 4 | 9 | 17 | 41 | 89 |
| 2 | Агуулах орчим | 7 | 12 | 17 | 23 | 91 |
| 3 | Харуулын орчим | 9 | 19 | 54 | 67 | 112 |
| 4 | Хогийн цэг | 3 | 7 | 21 | 49 | 63 |
| Хүлцэх хэм хэмжээ MNS 4585: 2016 | | 450 | 200 | 50 | 100 | 500 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Техникч Х.Нармандах /Х.Нармандах /
(гарын үсэг) (нэр)

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч /Б.Янжин /
(гарын үсэг) (нэр)

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Зураг 7. Төслийн талбайн агаарын хэмжилт

### 2.1.3. Ашиглагдаж буй машин механизм, техникийн засвар, үйлчилгээ тогтмол хийх

Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийн засвар үйлчилгээг тогмтол хийж гүйцэтгэдэг. Хөнгөн тэрэг, хүн тээвэр /автобус/- 5000 км тутамд, хүнд даац- 5000км, 150 мот/цаг тутамд, бобкайт, погрузчик- 200 мот/цаг тутамд тос солих болон бусад шаардлагатай үйлчилгээнүүдийг хийн ажиллаж байна.




Зураг 8. Техник ашиглалтын үзлэгийн пасспорт




Зураг 9. Тээврийн хэрэгслийн үзлэг

## 2.2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

### 2.2.1. Түүхий эдийн агуулах орчмын шороон талбайг бетондох

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс орчны тоосжилт үүсэх, хөрсөнд шатах тослох материал, асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд үйлдвэрийн тэсрэх материалын агуулахын хэсэг, болон үйлдвэрийн хажуугийн хэсгийн 200 м$^2$ талбайг бетондож хатуу хучилттай болсон.




Зураг 10. ТЭМ-ын хатуу хучилттай болгосон талбай



### 2.2.3. Цогцолборын ойр орчимд нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах

Нийтийн цэвэрлэгээ хийх хуваарийн дагуу сар бүрд үйлдвэрийн гадна орчинд 300-500 орчим метр зайд цэвэрлэгээг зохион байгуулж, хог хаягдлыг үйлдвэрийн хогийн цэгт түр хадгалан “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-та байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлдэг.



Зураг 12. Үйлдвэрийн орчмын хог хаягдлын цэвэрлэгээ

## 2.3. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

### 2.3.1. Шатах тослох материал алдагдсанаас хөрс ус бохирдуулж болзошгүй, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ажилчдад зөвлөмж мэдээлэл өгөх

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 1.2.2 хэсэгт ажилчдад “Шатах тослох материал алдагдсанаас байгаль орчин бохирдуулж болзошгүй түүнээс урьдчилан сэргийлэх” талаар ажилчдад зөвлөмж мэдээлэл өгч ажилласан.

### 2.3.2. Усыг зохистой ашиглах, гүний усны талаар ажилчдад мэдээлэл өгөх

Нийт ажилчдад “Үйлдвэрлэлийн болон унд ахуйн ус зохистой бөгөөд хэмнэлттэй ашиглах” талаар сургалт, зохион байгуулж, заавар зөвлөмж өгч, хяналт тавин ажиллаж байна.










Зураг 13. Сургалтын бүртгэл

### 2.3.3. Ус ашиглалттай холбоотой дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл авч ажиллах

Ус ашиглуулах дүгнэлтийн хүрээнд 2024 оны 04-р сарын 19-ний өдөр Цогтцэций сумын Засаг даргын А/47 тоот ус ашиглах зөвшөөрөл авч, 24/02 тоот гэрээ байгуулсан.



БАТЛАВ
ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА:
..............................Г.БАЦМАА

БАТЛАВ
"БЛАСТ " ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:
..............................А.ТЭМҮҮЛИН

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 04 сарын 19-ний өдөр Дугаар: 24/02 Цагаан-Овоо баг

НЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Усны тухай хуулийн 28.4 , 28.6 , 28.7, 29.1 –д заасны дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын гаргасан 2024 оны 04-р сарын 09-ний өдрийн 24/005 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын олгосон 2024 оны 04-р сарын 18-ний өдрийн А/128 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн :

Ус ашиглуулагчийг төлөөлж Өмнөговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын Байгаль хамгаалагч /Цогтцэций сумын/ Түмэн-Аюуш овогтой Болорцэцэг,

Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Ланд марк оффис 3 давхар, Утас-976-11-325995, Факс: 976-11-330117, Улсын бүртгэлийн дугаар- 901112504, Регистрийн дугаар- 2688336 "Бласт " ХХК–тай ус ашиглах талаар тохиролцож энэхүү гэрээг 2024 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл байгуулав.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

2.1 Ус ашиглах зориулалт: Үйлдвэрлэлийн зориулалтаар (Тэсрэх бодис , тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, тэсэлгээний ажил үйлчилгээ хийх)
2.2 Ашиглах усны хэмжээ: 5610.24 $м^3$
2.1 2.2.1 Унд ахуй , $м^3$ / хоног : 7.12 $м^3$
89 ажилтан * 80 л/хоног x 252/ажиллах хоног / = 1794.24 $м^3$
2.2.2 Үйлдвэрлэл $м^3$ : 2520 $м^3$
2.2.3 Мод усалгаа $м^3$ : 1296 $м^3$
2.3 Усны эх үүсвэр: Цогтцэций сумын Цагаан-Овоо баг Бласт ХХК-ийн өөрийн эзэмшлийн N 43⁰ 42` 14``, E 105⁰ 31` 48`` солбилцолд оршино. Худгийн гүн 120 м , 0,8 л/секунд ундаргатай.



2.4. Монгол улсын усны тухай хуульд заасны дагуу эрүүл ахуйн хамгаалалтын тогтоож ажиллах, түүнд хяналт тавьж ажиллана .
2.5. Зөвшөөрөлгүй цэгт хаягдал бохир ус болон ахуйн хог хаягдлыг хаяхгүй байх .
2.6 Усны эх үүсвэрт стандартын дагуу хамгаалалтын бүс тогтоож , улиралд 1 удаа шинжилгээнд хамруулж байх .
2.7. Усны тоолуур : LXSG-50
2.8. Ус ашигласны төлбөр хэмжээ :
-Унд ахуйд- 1794.24 $м^3$ *95.9= 172 068 төг
-Мод тарих усалгаанд- 1296 $м^3$ *71.928= 93 219 төг
-Тэсрэх бодис үйлдвэрлэхэд- 2520 $м^3$ *959,04= 2 416 781 төг
2.8.1 Усны нэгжийн үнийг Ус ашиглах дүгнэлтийн зөвлөмжийг үндэслэн " Усны экол – эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай " Монгол улсын засгийн газрын 2 оны 302 , 2013 оны 326 , 327-р тогтоолоор Галба өөш долоодын говийн сав газ тогтоосон газрын доорх усны экологи –эдийн засгийн суурь үнэлгээ, ашиглал зориулалтыг тооцох итгэлцүүр , хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөр дараах томьёогоор 1$м^3$ усны үнэлгээг тогтоов.
2.8.2 Унд ахуйн усны төлбөрийг 1$м^3$ x 3996 төгрөг x 0.16 x 15% = 95.904 төгрөг бол
2.8.3 Унд ахуйн болон өрөмдлөгийн усны төлбөрийг https://e-tax.mta.mn сай нэхэмжлэхэд суурилсан төлбөрийн дугаар үүсгэж төлнө.
2.9. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээг биохим шинжилгээний дүгнэлтийг үндэслэж "Ус бохирдуулсны төлбөрийн тухай" хууль бо түүнтэй холбоотой гарсан тогтоолын журмын дагуу ноогдуулалт хийх бо ноогдуулалт хийж болно .

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19. 19.1.2, 19.1.4, 26.1 , 30.1 , 30.2 , 31.1, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23. 23.8.9-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. БУСАД

4 1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эх хүчин төгөлдөр болно.
4.2.Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгн хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
4.3.Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
4.4.Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичг үйлдэнэ.



4.5.Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
4 5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
4.5.2.Аль нэг тал татан буугдсан бол
4.6.Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Ус ашиглуулагчийг төлөөлж:
Цогтцэций сумын байгаль хамгаалагч
................................/ Т. Болорцэцэг /
Хаяг : Цогтцэций сум ЗДТГазар 2 давхар 200 тоот
Утас : 80858596

Ус ашиглагчийг төлөөлж :
" Бласт " ХХК-ийн Таван толгой салбарын дарга
................................/ Д.Одхүү/
Хаяг : Цогтцэций сум ,Цагаан-Овоо баг
Утас : 32-59-95, 99750550

Зураг 15. Ус ашиглах гэрээ

### 2.3.4. Холбогдох байгууллагаас хаягдал усны дүгнэлт, гэрээ зөвшөөрөл авч ажиллах

Ус ашигласны төлбөрийг усны эх үүсвэр дээр суурьлуулсан баталгаажуулсан усны тоолуурын заалтаар сар бүрийн 25-ны өдөр бүртгэл хөтөлж, сумын байгаль хамгаалагч, БО-ны хяналтын улсын байцаагчаар хянуулдаг. 2024 оны эхний 09 сарын байдлаар 3’000 м$^3$ ус ашиглаж, ус ашигласны төлбөрт **2,175,671.88** төг төлсөн байна.

Хүснэгт. 7 Нийт ашигласан усны хэмжээ төлбөрийн мэдээлэл

| № | Хугацаа | Үйлдвэрт | | | Унд-ахуй/ | | | Усалгаа | | | Нийт төлбөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | 12/25 - 01/25 | 338 | 959.4 | 324,277.20 | 92 | 96 | 8832 | | | | 333,109.20 |
| **2** | 01/25 - 02/25 | 284 | 959.4 | 272,469.60 | 94 | 96 | 9024 | | | | 281,493.60 |
| **3** | 02/25 - 03/25 | 167 | 959.4 | 160,219.80 | 119 | 96 | 11424 | | | | 171,643.80 |
| **4** | 03/25 - 04/25 | 181 | 959.4 | 173,651.40 | 94 | 96 | 9024 | | | | 182,675.40 |
| **5** | 04/25 - 05/25 | 154 | 959.4 | 147,747.60 | 73 | 96 | 7008 | | | | 154,755.60 |
| **6** | 05/25 - 06/25 | 150 | 959.4 | 143,910.00 | 67 | 96 | 6432 | 54 | 71.93 | 3884.22 | 154,226.22 |
| **7** | 06/25 - 07/25 | 199 | 959.4 | 190,920.60 | 57 | 96 | 5472 | 32 | 71.93 | 2301.76 | 198,694.36 |
| **8** | 07/25 - 08/25 | 346 | 959.4 | 331,952.40 | 58 | 96 | 5568 | 4 | 71.93 | 287.72 | 337,808.12 |
| **9** | 08/25 - 09/25 | 370 | 959.4 | 354,978.00 | 61 | 96 | 5856 | 6 | 71.93 | 431.58 | 361,265.58 |
| | Нийт | 2189 | | 2,100,126.6 | 715 | | 88’800 | 96 | | 6905 | **2,175,671.88** |
| **Нийт ашигласан ус 3’000 м$^3$** | | | | | | | | | | | |




| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйлдвэр | 338 | 284 | 167 | 181 | 154 | 150 | 199 | 346 | 370 |
| Ахуйн хэрэглээ | 92 | 94 | 119 | 94 | 73 | 67 | 57 | 58 | 61 |
| Усалгаа | | | | | | 54 | 32 | 4 | 6 |



"БЛАСТ" ХХК -ийн Тавантолгой салбар

ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН ХЯНАЛТЫН АКТ

2024 оны 04 сарын 26-ны өдөр

| № | Худгийн нэр, зориулалт | Тоолуурын заалт | | Нийт сарын хэрэглээ /м³/ | Тоолуурын зураг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2024.03.25 | 2024.04.25 | | 2024.03.25 | 2024.04.25 |
| Нийт хэрэглээ | | 7'160 | 7'435 | 275 | Худаг -1 | |
| 1 | Үйлдвэр | 7'160 | 7'435 | 181 | | |
| 2 | Унд-ахуй, | 2'067 | 2'150 | 94 | | |

Баталгаажуулалт хийсэн:

Байгаль орчны хяналтын улсын байцаагч: ................/ Т.Бозорцэцэг /

Байлцсан:

"БЛАСТ"ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн: ................/ Б.Бат-Эрдэнэ /



"БЛАСТ" ХХК –ийн Тавантолгой салбар

✓ ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН ХЯНАЛТЫН АКТ

2024 оны 03 сарын 26–ны өдөр

| № | Худгийн нэр, зориулалт | Тоолуурын заалт | | Нийт сарын хэрэглээ /м³/ | Тоолуурын зураг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2024.02.25 | 2024.03.25 | | 2024.02.25 | 2024.03.25 |
| Нийт хэрэглээ | | 6'874 | 7'160 | 286 | Худаг -1 | |
| 1 | Үйлдвэр | 6'874 | 7'160 | 167 | | |
| 2 | Унд-ахуй, | 1'948 | 2'067 | 119 | | |

Баталгаажуулалт хийсэн:

Байгаль орчны хяналтын улсын байцаагч: ................/ Э.Отгонжаргал /

Байлцсан:

"БЛАСТ"ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн: ................/ Б.Бат-Эрдэнэ /

Зураг 18. Усны тоолуурын хяналтын акт 1-2-р сар


“БЛАСТ” ХХК –ийн Таван толгой салбар

ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН ХЯНАЛТЫН АКТ

2024 оны 05 сарын 26–ны өдөр

| № | Худгийн нэр, зориулалт | Тоолуурын заалт | | Нийт сарын хэрэглээ /м³/ | Тоолуурын зураг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2024.04.25 | 2024.05.25 | | 2024.04.25 | 2024.05.25 |
| Нийт хэрэглээ | | 7435 | 7662 | 227 | Худаг -1 | |
| 1 | Үйлдвэр | 7’435 | 7’662 | 154 | | |
| 2 | Унд-ахуй, | 2’150 | 2’223 | 73 | | |

Баталгаажуулалт хийсэн:

Байгаль орчны хяналтын улсын байцаагч: ............ / Т.Болорцэцэг /

Байлцсан:

“БЛАСТ”ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн: ............ / Б.Бат-Эрдэнэ /


“БЛАСТ” ХХК –ийн Таван толгой салбар

ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН ХЯНАЛТЫН АКТ

2024 оны 06 сарын 25–ны өдөр

| № | Худгийн нэр, зориулалт | Тоолуурын заалт | | Нийт сарын хэрэглээ /м³/ | Тоолуурын зураг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2024.05.25 | 2024.06.25 | | 2024.05.25 | 2024.06.25 |
| Нийт хэрэглээ | | 7662 | 7933 | 271 | Худаг -1 | |
| 1 | Үйлдвэр | 7662 | 7933 | 150 | | |
| 2 | Унд-ахуй, | 2223 | 2290 | 67 | | |
| 3. | Угаалга | | 54 | 54 | | |

Баталгаажуулалт хийсэн:

Байгаль орчны хяналтын улсын байцаагч: ............ / Т.Болорцэцэг /

Байлцсан:

“БЛАСТ”ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн: ............ / Т.Эрдэнэбат /

Зураг 19 Усны тоолуурын хяналтын акт 03, 04-р сар


“БЛАСТ” ХХК –ийн Таван толгой салбар

ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН ХЯНАЛТЫН АКТ

2024 оны 01 сарын 29–ний өдөр

| № | Худгийн нэр, зориулалт | Тоолуурын заалт | | Нийт сарын хэрэглээ /м³/ | Тоолуурын зураг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2023.12.25 | 2024.01.25 | | 2023.12.25 | 2024.01.25 |
| Нийт хэрэглээ | | 6’252 | 6’590 | 430 | Худаг -1 | |
| 1 | Худаг1 Үйлдвэр | 6’252 | 6’590 | 338 | | |
| 2 | Худаг1 Унд-ахуй, | 1’762 | 1’854 | 92 | | |

Баталгаажуулалт хийсэн:

Байгаль хамгаалагч: ............ / Э.Отгонжаргал.

Байлцсан:

“БЛАСТ”ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн: ............ / Б.Бат-Эрдэнэ /


“БЛАСТ” ХХК –ийн Таван толгой салбар

ХУДГИЙН УСНЫ ТООЛУУРЫН ХЯНАЛТЫН АКТ

2024 оны 02 сарын 26–ны өдөр

| № | Худгийн нэр, зориулалт | Тоолуурын заалт | | Нийт сарын хэрэглээ /м³/ | Тоолуурын зураг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2024.01.25 | 2024.02.25 | | 2024.01.25 | 2024.02.25 |
| Нийт хэрэглээ | | 6’590 | 6’874 | 378 | Худаг -1 | |
| 1 | Үйлдвэр | 6’590 | 6’874 | 284 | | |
| 2 | Унд-ахуй, | 1’854 | 1’948 | 94 | | |

Баталгаажуулалт хийсэн:

Төслийн орчны хяналт шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд 2024 оны 06-р сарын 17-нд гүний худаг, 07-р сарын 23-нд хаягдлын сангаас стандартад заагдсан аргачлалын дагуу дээж цуглуулан химийн, нянгийн задлан шинжилгээ болон усны физик шинж чанарыг Өмнөговь аймгийн стандарт хэмжилзүйн хэлтсийн лабороторид шинжилгээнд хамруулсан.

Гүний худгийн усны дээжинд хийсэн усны химийн задлан шинжилгээний дүнг /Хүснэгт 9-д/ үзүүлэв.

Хүснэгт. 9 Гүний худгийн усны шинжилгээний дүн

| Шинжилсэн үзүүлэлтүүдийн | Ундны ус стандарт MNS 0900:2015 | Үйлдвэрийн хэрэглээний ус, шинжилгээний дүн |
|---|---|---|
| Нэр хэмжих нэгж | | |
| ББЕТ | 1 мл-т 100-с ихгүй | Нянгийн тоо |
| Salmonella spp | 25 мл-т илрэхгүй | Илрээгүй |
| Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян/ ялтсан шүүлтүүр/ | 100 мл-т | Илрээгүй |
| Аммони | 1.5 мг/л | 0.03мг/л |

| | | |
|---|---|---|
| Кальци | 100 мг/л | 191.382мг/л |
| Магни | 30 мг/л | 84.152 мг/л |
| pH | 6.5-8.5 | 6.82 |
| Хатуулаг | 7мг-экв/л | 16.5-экв/л |
| Хлорид | 350мг/л | 400.529мг/л |
| Хуурай үлдэгдэл | 1000мг/л | 952 мг/л |
| Цахилгаан дамжуулах чанар | 1мСм/см | 1.864м См/см |
| Зэс | 1л-т 2мг/л | 0.01мг/л |

### 10.2. Хөрс, хөрсөн бүрхэвчийн шинжилгээ, судалгаа

Төслийн талбайд үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж буй байгууламжийн ойролцоо өмнөх жилийн дээж авсан цэгт давтан, 4 цэгээс дээж авч шинж чанар болон бохирдлыг тодорхойлж өмнөх оны шинжилгээний дүнтэй харьцуулав.

**Хөрсний хэв шинж**

Төслийн талбайд үйлдвэрийн байгуулалтын үед болон үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсний үржил шим бүхий өнгөн үе давхарга үгүй болж маш нягт хатуу бүтэцтэй суурь хурдас ил гарсан байна.

**Хөрсний шинж чанар, бохирдлын түвшин**

Төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хувьд хамгийн түгээмэл тархсан хөрс нь хээржүү цөлийн цайвар бор хөрс, уулын цөлөрхөг хээрийн бор хөрс, цөлөрхөг хээрийн нугат далд глейрхэг бор хөрс тархсан байна.

**Хөрсний бохирдол, хүнд металлын агууламж**

Хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх (хүлцэх) дээд хэмжээг тогтоох бөгөөд стандартад заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдолд орсон гэж үздэг. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS85850:2016 стандартад заасан хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд (хүлцэх) хэмжээ, хортой, аюултай агууламжуудыг хөрсний бохирдол, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, тухайн газар нутгийн байгаль орчны мониторинг, хяналтын чиглэлээр хийгдэж буй судалгааны ажлуудад мөрдлөг болгодог.

Хүснэгт. 10 2024 оны Хөрсний хүнд металлын агууламж

| Хөрсний хүнд металлын агууламж | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Ni | Cd | Pb | Cu | Zn | Cr |
| Хогны цэг /Хашааны гадна/ | 12.96 | <1.0 | 8.29 | 45.49 | 59.21 | 24.18 |
| Уурын зуух / Трансформатын хажууд/ | 19.97 | <1.0 | 10.77 | 69.73 | 93.39 | 40.72 |
| Тэсрэх материалын агуулах /Үйлдвэр хажууд/ | 12.37 | <1.0 | 8.44 | 46.46 | 67.48 | 29.55 |
| Үйлдвэрийн хаягдлын сан /Үйлдвэрийн байрны хажууд/ | 14.35 | <1.0 | 8.93 | 56.80 | 66.64 | 25.85 |
| **MNS 5850:2019** | **150.0** | **3.00** | **100.0** | **100.0** | **300.0** | **150.0** |

Үйлдвэрийн хашаан дотор, гадна, уурын зуух, үйлдвэр хакууд гэсэн 4 цэгээс өнгөн хөрсний дээж авч өргөн тархалттай хүнд элементүүдийг тодорхойлсон. Хортой хүнд металл гэдэгт дараах 10 хүнд металл багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хүнцэл (As), хром (Cr), цайр (Zn), кобальт (Co), никель (Ni), зэс (Cu), стронций (Sr), ванадий (V) орно (MNS 5850 : 2019). Эдгээрээс байгальд хамгийн өргөн тархалттай 6 хүнд элементийг(Ni, Cd, Pb, CU, Zn, Cr) сонгон авч, Монгол улсын стандарттай харьцуулан, бохирдлын түвшнийг тооцоолсон. Лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд төсөл хэрэгжих талбайд хүнд элементийн дундаж агууламжийн хувьд Cd <1 буюу ядуулаг агууламжтай, Ni-12- 19.мг/кг, Cu 45-69мг/кг, Zn-59.93мг/кг, Pb-8мг/кг, 10-мг/кг тус тус агууламжтай байгаа бөгөөд Zn> Cr> Pb> Cu> Ni> Cd агууламжтай байна. Өнгөн хөрсний хүнд элементийн агууламж MNS5850:2019 стандартад заасан утгаас хэтрээгүй буюу бохирдол илрээгүй байна.



Хүснэгт. 11. 2020-2024 он хүртэл хөрсөн дэх хүнд металлын агууламж мг/кг

| **Хүнд металлын агууламж мг/кг** | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **NI** | | | | **Pb** | | | | **Cu** | | | | **Zn** | | | | Cr | | | |
| **Сүүлийн 4 жил** | **2020** | **2021** | **2022** | **2024** | **2020** | **2021** | **2022** | **2024** | **2020** | **2021** | **2022** | **2024** | **2020** | **2021** | **2022** | **2024** | **2020** | **2021** | **2022** | **2024** |
| Хашааны гадна | 20.6 | 14.92 | 13.7 | 12.96 | | 7.45 | 7.9 | 8.29 | 9.1 | 24.64 | 41.1 | 45.49 | ND | 172.6 | 52.1 | 59.21 | ND | 26.36 | 17.9 | 24.18 |
| Хашааны дотор зоолгын хажууд | 17.1 | 16.32 | 16.3 | 12.37 | 3.1 | 9.29 | 9.29 | | 12.7 | 52.3 | 52.3 | | ND | 70.26 | 70.26 | 67.48 | ND | 31.94 | 31.94 | |
| Үйлдвэрийн байрны хажууд | 17.1 | 14.41 | 16.4 | 14.35 | 17.4 | 8.01 | 11.8 | 8.93 | 11.8 | 18 | 38.2 | 56.8 | 10.3 | 45.71 | 66.7 | 66.64 | ND | 24.74 | 38.2 | 25.85 |
| Транфсорматын хажууд | 15.3 | 20.29 | 20.3 | 19.97 | 11.1 | 9.57 | 9.57 | 10.77 | 9.57 | 24.98 | 24.98 | 69.73 | 14.6 | 62.34 | 62.34 | 93.39 | 9.45 | 42.32 | 42.32 | 40.72 |
| **MNS5850: 2019** | 150 | | | | 100 | | | | 100 | | | | 300 | | | | 150 | | | |

Бохирдуулагч тус бүрээр авч үзэхэд никелийн, агууламж өмнөх оны шинжилгээний дүнтэй харьцуулахад 0.74-3.93мг/кг буурсан байна. Хар тугалгын агууламжийн хувьд 2020-2022 онд 3.1-17.4мг/кг агууламжтай байсан ба 2024 онд 8.29-11.78мг/кг байгаа нь өмнөх онуудтай адил буюу дундаж үзүүлэлттэй байна. Харин зэсийн хувьд энэ жилийн шинжилгээний дүнг бусад онуудтай харьцуулахад 1-2 дахин их байна. Хөрсөн дэх хромын агууламж хашааны гадна буюу хогын цэг орчим 2022 оны шинжилгээний дүнгээс 0.5 дахин их байна. Цайрын агууламж трансформатын хажууд 31.6 мг/кг их хэдий ч хөрсөн дэх хүнд металлын мониторингийн 4 цэгээс авсан 2024 оны дээж нь MNS 5850:2019 стандартад утгад байна.

График 3. 2020-2024оны хөрсөн дэх хүнд металлын агууламж






Зураг 44. ТМ-ын агуулах, үйлдвэрийн хажуу талаас дээж цуглуулалт



Зураг 45. Хогны цэг, уурын зуух дээж цуглуулалт

**Хөрсний зүсэлт, морфологи шинж чанар**

Хээрийн судалгааны явцад хийсэн зүсэлт, морфологи тогтцын бичлэг, авсан дээжний лабораторийн задлан шинжилгээний дүнг үндэслэн тодорхойлов.

Хүснэгт. 12 Хөрсний морфологи бичиглэл

| Хөрсний зүсэлтийн дугаар: -1 | |
|---|---|
| Огноо | 2024.08.15 |
| Байршил | Өмнөговь аймаг, Цогт цэций сум<br>43°42'14.65"N<br>105°31'35.11"E |
| Газрын гадарга | Нам ухаа толгод |
| Налуу | 0-5° |
| Ургамал бүрхэц | 25-30% |
| Хөрсний нэр: | Цөлөрхөг хээрийн бор хөрс |
| Гадаргын төрх байдал |  |
| **А**:0-10см: Чийг бага, цайвар өнгөтэй, ургамлын үндэс сийрэг тархсан, элсэнцэр механик бүрэлдхүүнтэй, сайр чулуутай шилжилт өнгөөр тод ажиглагдана.<br>В-10-50 см : Чийг бага, ургамлын үндэс тачир, элсэрхэг бүрэлдэхүүнтэй | <br>Зураг 46. Хөрсний зүсэлт |

**Хөрсний агрохимийн шинжилгээ**

Үйлдвэрийн бүсийн орчимд цөлөрхөг хээрийн бор хөрс тархалттай ба Химы шинж чанарын задлан шинжилгээний дүнгээс үзэхэд үржил шимт давхаргын ялзмагийн агууламж багатай, ургамалд ашиглагдаг шим тэжээлийн бодис болох хөдөлгөөнт фосфор бага, хөдөлгөөнт калиар дунд хангамжтай, цөлөрхөг хээрийн бор хөрсний хувьд хөрсний усан тунгаамлын орчин бүх үе давхаргын хэмжээнд хүчтэй шүлтлэг (PH>8.5) байна.

Хүснэгт. 13. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Шинжилгээний дүн | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Уурын зуух орчим | ТМ-ын агуулах | Харуулын байр | Хогны цэг |
| 1 | Орчин-PH | | 8.87 | 9.07 | 8.41 | 8.32 |
| 2 | Чийг | % | 0.70 | 0.78 | 0.63 | 0.71 |
| 3 | Сульфат/SO4 | Мг/кг | 54.1 | 221.4 | 156.8 | 751.6 |
| 4 | Нитрат/NO3 | Мг/кг | 40.7 | 230.7 | 142.6 | 152.0 |
| 5 | Аммони/NH4 | Мг/кг | 15.0 | 137.2 | 12.0 | 5.3 |
| 6 | Ялзмаг | % | 1.74 | 1.98 | 1.42 | 1.52 |
| 7 | Фосфор /$P_2O_5$/ | Мг/кг | 11.2 | 10.3 | 5.3 | 4.04 |

### 10.3. Агаарын чанарын шинжилгээ, судалгаа

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн агаарын чанарын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлохдоо төслийн талбай дахь агаар бохирдуулах боломжтой эх үүсвэрүүд орчимд хэмжсэн агаарын чанарын хэмжилтийн дүн мэдээг ашигласан.

Төслийн үйлдвэрийн хашааны гадна, хашааны дотор овоолго шороонын хажууд, үйлдвэрийн байрны хажууд, өндөр хүчдэлийн шонгийн хажууд зэрэг газруудад агаарын 4, хөрс 4, цэвэр усны 1 дээжүүдийг зохих стандарт, шаардлага, аргачлалын дагуу цуглуулж, мөн газар дээрх хэмжилт судалгааг хийж гүйцэтгэлсэн. Дээж цуглуулсан болон хэмжилт хийсэн цэгүүдийг дээжний төрлөөр доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Дээж цуглуулсан болон хэмжилт хийсэн цэгүүдийг байрлал

Хүснэгт. 14 Дээж цуглуулсан цэгүүд

| № | Хэмжилтийн талбай | Дээжний төрөл | | |
|---|---|---|---|---|
| | | Ус | Хөрс | Агаар |
| **Өмнөговь аймаг Цогтцэций сум** | | | | |
| 1 | Үйлдвэрийн хаягдлын сан орчим | 2 | 1 | 1 |
| 2 | Агуулах орчим | | 1 | 1 |
| 3 | Оффис, уурын зуух орчим | | 1 | 1 |
| 4 | Хогны цэг | | 1 | 1 |
| | Нийт дээжний тоо | **2** | **4** | **4** |

**Агаар дахь тоосонцрын агууламжийн судалгаа**

Хяналт шинжилгээний ажлын хүрээнд тухайн төслийн талбайд тоосонцор болон дуу чимээний түвшинг тодорхойлох, мөн бусад эх үүсвэрийн нөлөөллийг гадаад болон дотоод орчны агаарт тодорхойлсон. (Зураг 1).

А) Б) В)




Зураг 47. Агаар бохирдуулагч бодисын хэмжилтийн багаж

Агаар орчныг бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж хуваaж үздэг. Агаарын бохирдлын аюултай эх үүсвэрт хүний үйл ажиллагаанаас хамааралтай бохирдолт ордог ба энэ нь ихэвчлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэлтэй тоосжилттой холбоотой байдаг.

Хүснэгт. 15. Агаар дахь тоосонцорын хэмжилтийн дүн

| № | Хэмжилт хийсэн цэг | Хүхэрлэг хий/SO2 | Азотын давхар исэл NO2 | PM 2.5 тоосонцор | PM 10 тоосонцор | Нийт тоос TSP |
|---|---|---|---|---|---|---|
| | | МКг/м3 | МКг/м3 | МКг/м3 | МКг/м3 | МКг/м3 |
| **1** | Оффис уурын зуух орчим | 4 | 9 | 17 | 41 | 89 |
| **2** | Агуулах орчим | 7 | 12 | 17 | 23 | 91 |
| **3** | Харуулын байр орчим | 9 | 19 | 54 | 67 | 112 |
| **4** | Хогны цэг | 3 | 7 | 21 | 49 | 63 |
| **Хүлцэх хэм хэмжээ MNS 4585:2006** | | **450** | **200** | **50** | **100** | **500** |

Үр дүнгээс харахад төслийн талбайд нарийн ширхэгт тоосонцрын агуулламж 17мкг/м3 -54мкг/м3 хооронд, хамгийн өндөр утга нь харуулын байр орчим стандартаас 4 мкг/м3 хэмжээгээр илүү байна. Бусад цэгүүдэд агаарийн чанар стандарт утгад байна. Том ширхэгт тоосонцор болон Хүхэрлэг хий/SO2, Азотын давхар исэл NO2, бохирдуулагч бодисын хэмжээ хэмжилт хийсэн 4 цэгт стандартаас утгаас хэтрээгүй байна/

График 4. 2024 оны агаарын чанарын хэмжилт




**Дуу шуугианы судалгаа**

Агаарын чанарын дээрх үзүүлэлтүүдээс гадна тухайн орчинд үйлдвэрийн янз бүрийн үйл ажиллагаанаас гарах дуу шуугианы түвшинг гадаад орчинд 4 цэгт хэмжилт судалгааг хийж тодорхойлов. Хэмжилтийн дүнгээс харахад төслийн талбай дахь дуу шуугианы түвшин 50-72дБА байгаа бөгөөд 2 цэгүүдэд дуу шуугианы түвшин зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

График 5. Дуу шуугианы хэмжилт




## 10.4. Хаягдал усны шинжилгээ

Үйлдвэрийн ахуйн хэрэглээний болон үйлдвэр, уурын зуухны хаягдал усны нянгийн шинжилгээний дүнг хүснэгт 16-т харуулав. Шинжилгээний дүнгээс үзэхэд MNS4943:2015 хаягдал усны ерөнхий шаардлага стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

Хүснэгт. 16 Үйлдвэрийн ахуйн болон хэрэглээний хаягдал усны шинжилгээний дүн

| | **Шинжилсэн үзүүлэлтийн хэмжих нэгж** | **Шаардлага** | **Шинжилгээний дүн** |
|---|---|---|---|
| **Ахуйн хаягдал бохир ус** | Эмгэг төрөгч нян | 1 мл-т илрэхгүй | Илрээгүй |
| | Биохимийн хэрэгцээт хүчил төрөгч | 400 мгО/л | 225.2 |
| | pH | 6-9 | 7.67 |
| | умбуур бодис | 400 мг/л | 157 мг/л |
| | Хлорид | 1000 мг/л | 74.43 мг/л |
| **Үйлдвэрийн ашиглалтын хаягдал бохир ус** | Эмгэг төрөгч нян | 1 мл-т илрэхгүй | Илрээгүй |
| | Биохимийн хэрэгцээт хүчил төрөгч | 400 мгО/л | 220.5мгО/л |
| | pH | 6-9 | 6.49 |
| | умбуур бодис | 400 мг/л | 313 мг/л |
| | Хлорид | 1000 мг/л | 198.49мг/л |




Зураг 48. Мониторингийн цэгүүдийн байршил

# БҮЛЭГ 11. АЙМАГ, СУМ ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТЫН АЖИЛ, НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ

## БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

“БЛАСТ” ХХК-ийн Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах төслийг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын  Цагаан-Овоо багийн иргэдийн нийтийн хурлаар байгаль орчны менежментийн төлөвлөгийний биелэлтийн танилцуулга хийж, нарийвчилсан үнэлгээг хэлэлцүүлсэн.

Хурлын шийдвэрээр:

- Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах талаар жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулах,
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг тухай бүр Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, багийн Засаг дарга, ИНХ-ын хуралдаан даргалагч, багийн хурлын зөвлөлтэй хамтарч ажиллахыг үүрэг болгон  “БЛАСТ” ХХК-ийн “Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах цогцолбор”-ын Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг дэмжлээ.



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЦОГТЦЭЦИЙ СУМЫН
ЦАГААН-ОВОО БАГИЙН ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 24 өдөр Дугаар 12/5 Өгөөмөр

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын тайланг хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6, 32 дугаар зүйлийн 32.8.1, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8, 18 дугаар зүйлийн 18.4, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/03 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах" журмын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн Цагаан-Овоо багийн Иргэдийн нийтийн хурлаас ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа "Бласт" ХХК-ийн "Тэсрэх бодисын агуулах, үйлдвэрийн цогцолбор" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг гүйцэтгэсэн "Төгрөг баян хангай" ХХК-ийн ажлын тайланг дэмжсүгэй.
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах талаар жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн ажлын тайланг тухайн жилдээ багийн Иргэдийн нийтийн хуралд мэдээллэж ажиллахыг "Бласт" ХХК-д даалгасугай.
3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг тухай бүр багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, багийн Засаг дарга, ИНХ-ын хуралдаан даргалагч, багийн хурлын зөвлөлтэй хамтарч ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ У.ТҮВШИНБАЯР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦАГААН ОВОО БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 09 сарын 24 өдөр Цогтцэций сум

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн Иргэдийн нийтийн хурал 2024 оны 09 сарын 24-ний өдөр тус сумын Соёлын төвд 11 цаг 15 минутад эхлэв. Хуралд Цагаан-Овоо багийн Засаг дарга Б.Энхбаатар, тус багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга У.Түвшинбаяр, "Бласт" ХХК-ийн Салбарын дарга Д.Одхүү, Байгаль орчны мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ, "Төгрөг Баян Хангай" ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Г.Гэрэлмаа болон иргэдийн төлөөлөл оролцов.

Хэлэлцэх асуудал: "Бласт" ХХК-ийн "Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор" төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг хэлэлцэх.

Хэлэлцэх сэдвийн дагуу уг төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг "Төгрөг Баян Хангай" ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Г.Гэрэлмаа танилцуулав.

Хурал даргалагч У.Түвшинбаяр: БОННҮ-ний нэмэлт тодотгол тайлантай танилцлаа.Тайлантай холбоотой асуултаа компанийн төлөөлөл хүмүүсээс асууж тодруулаад, саналаа илэрхийлье.

Иргэн Д.Энхтуяа: Танайх 2023 онд БОННҮ тайлан хэлэлцүүлж байсан, яагаад энэ жил дахин тайлан хэлэлцүүлж байгаагаа дахиад хэлээд өгөөч.

"Төгрөг Баян Хангай" ХХК-ийн мэргэжилтэн Г.Гэрэлмаа: "Бласт" ХХК-нь одоо үйл ажиллагаа явуулж буй "Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах" төсөлдөө өргөтгөл хийх, мөн компанийн ажилчдын амрах байгуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Байгаль орчны үнэлгээний журамд заасны дагуу БОННҮ-нд нэмэлт тодотгол хийлгэх шаардлага үүссэн учир БОННҮ-нд нэмэлт тодотгол тайланг боловсруулан энэхүү хурлаар хэлэлцүүлж байгаа юм.

Багийн Засаг дарга Б.Энхбаатар: Малчдын дунд тэсэлгээний компаниуд зөвшөөрөлгүй замаар явлаа гэх яриа гарч байсан. Тээвэрлэлтийнхээ талаар мэдээлэл өгөөч.

"Бласт" ХХК-ийн Үйлдвэрийн дарга С.Магнайбаяр: Манайх түүхий эдийн тээврийг "Аюултай ачаа, химийн бодис тээвэрлэх" тусгай зөвшөөрөлтэй "Бласт Автомотив" ХХК хариуцан ажилладаг бөгөөд маршрутын хувьд Цагдаагийн Ерөнхий газрын бүртгэл хяналтын төвөөс зөвшөөрөл авч, сумын Засаг даргын баталсан чиглэлийн дагуу тээврийг хийж байгаа.

Иргэн Х.Туяа: Сум орон нутагт үйл ажиллагаа явуулаад хэдэн жил болж байна, орон нутагтай яаж хамтран ажиллаж байна вэ?

"Бласт" ХХК-ийн Таван толгой салбарын дарга Д.Одхүү: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай байгууллага нь 2001 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа тэсэлгээний ажил үйлчилгээ, тэсрэх бодисын үйлдвэрлэлийн чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулж буй салбартаа тэргүүлэгч үндэсний компани гэдгийг дуулгахад таатай байна. Бид үйл ажиллагаа явуулахаас гадна тухайн орон нутагтаа нийгмийн хариуцлагын хүрээнд үр, өгөөжтэй ажлуудыг хийж хэрэгжүүлэхийг зорьж ажилладаг. Тухайлбал орон нутгийн хөгжилд хувь нэмэр үүднээс багийн төвийн шинээр баригдсан байрны хурлын өрөөний тохижилт, "Тэрбум мод" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж хашаажуулан арчлах, Дэлхийн усны өдрийн хүрээнд жил бүр Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд зохион байгуулагддаг тэмцээнд дэмжлэг үзүүлэх, Цогтцэций сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан сумын төвд 3x3 стандарт сагсны 2 талбай байгуулах гэх мэт ажлуудыг зохион байгуулж, ажилласан байна.

Иргэн Х.Туяа: Та бүхний тавьсан танилцуулгаас мэдээлэл авлаа. Мөн түрүү жил тайлангаа хэлэлцүүлж байсан учраас өөр асууж тодруулах зүйлгүй байна.

Багийн Засаг дарга Б.Энхбаатар: "Бласт" ХХК нь сум, багтай байнгын хамтарч ажилласаар ирсэн байгууллага. Бүх нийтийн цэвэрлэгээ, тэмдэглэлт өдрүүд зэрэгт тухай бүр ач холбогдол өгч, хүн хүч гарган оролцдог. Цагаан сараар сумын төвийн өндөр настнуудад хүндэтгэл үзүүлэх, малчдад болон зэрлэг ан амьтдад өвс тэжээл тарааж өгөх гэх мэт ер нь нийгмийн хариуцлага дажгүй сайн компани, цаашид ч хамтран ажиллах байх гэж бодож байна.

Хурал даргалагч У.Түвшинбаяр: За та бүхэнд өөр асуулт, санал байна уу?

Хурал даргалагч Түвшинбаяр: БОННҮ-нд тавигдсан заавар зөвлөмжийг мөрдөж, Байгаль хамгаалах төлөвлөгөөнийхөө дагуу сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, тайланг Иргэдийн нийтийн хуралд мэдээлж ажиллах нь зүйтэй гэж хэлмээр байна.

"Бласт" ХХК-ийн Таван толгой салбарын дарга д.Одхүү: Тэгэлгүй яахав, бид холбогдох хууль журмын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж, жил бүр ажлаа танилцуулж ажиллах болно.

Шийдвэрлэсэн нь: Санал, асуулт байхгүй бол саналаа хураая гэснээр хуралд оролцогчид "Бласт" ХХК-ийн "Тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор"-ын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг дэмжлээ.

ИНХ-ыг даргалагч ........................................ / У.Түвшинбаяр/

**Аймаг, сум орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:**

✓ Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 13-нд Цогтцэций сумын ЗДТГ-ын зохион байгуулсан намрын мод тарих ажилд оролцлоо. “Таван толгой” ХК-с 300 ширхэг 2 настай Хайлаас модны суулгацыг авч Цагаа овоо хайрхны энгэрийн цэцэрлэгт хүрээлэнд “ТаванТолгой” ХК, “Спейншл майнинг", ХХК-тай хамтран мод тарилтын ажлыг хийж гүйцэтгэлээ.




Зураг 49. Намрын мод тарих өдөрлөг



Зураг 50. Мод тарих бэлтгэл ажил хийгдэж буй байдал/

✓ Цогтцэций сумийн 100 жилийн ойг угтсан арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн гадаа талбайг сагсан бөмбөгийн 3x3 стандарт талбай болгож тохижуулан хүлээлгэн өглөө.







✓ Цогтцэций сумын Цагаан овоо багийн үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ой тохиолдуулан сумын төвд шинээр баригдсан багийн төвийн байрны хурлын өрөөний тохижилтод телевизор болон 30 ширхэг, хурлын эвхэгддэг ширээтэй сандал хүлээлгэн өгч хамтарч ажилласан.




✓ Өмнөговь аймгийн цогтцэций сумын Засаг даргын А/321 тоот “Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах тухай” захирамжийн дагуу “Бласт” ХХК нь 910 га талбайд үйлдвэр, тэсэлгээний хэсгийн нийт 27 ажилтантай 2 өдөр нийтийн цэвэрлэгээ зохион байгууллаа.




Зураг 51. Цэвэрлэгээний талбай



Зураг 52. Цэвэрлэгээ хийж буй байдал

✓ Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “УС БА ЭНХ ТАЙВАН” уриан дор зохиосон байгуулсан ерөнхий боловсролын сургуулын сурагчдын дундах “Дэвжээ” тэмцээнд оролцсон 5-р сургуулийн сурагчдын тэмцээний бэлтгэл, хувцас хэрэгсэлд 973.0 мян дэмжлэг үзүүллээ.






ӨМНӨГОВЬ АЙМАГ
ДАЛАНЗАДГАД СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ТАВДУГААР СУРГУУЛЬ

6 дугаар баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46052
Утас: 70531255
Цахим шуудан: surguuli5@gmail.com

2024.03.27 № 62
танай ______ -ны № ______ -т

БЛАСТ ХХК-Д

Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас дэлхийн усны өдөрт зориулан "УС БА ЭНХ ТАЙВАН" уриан дор зохион байгуулж байгаа "ДЭВЖЭЭ" тэмцээнд манай сургуулийн дэргэдэх "Дөл" клубийн 10 суралцагч оролцохоор бэлтгэж байна.

Тус "Дөл" клубийн сурагчдад тэмцээний хувцас хэрэглэл бусад материал хэрэглэгдэхүүний шаардлага үүсээд байгаа тул санхүүгийн дэмжлэг үзүүлж өгнө үү?

Зардлын тооцоог хавсралтаар гарган хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ЗАХИРАЛ Г.ШУРЦЭЦЭГ

462401109

E:\БИЧИГ ХЭРЭГ\yvuulsan bichig\A5.docx

Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас
Дэлхийн усны өдөрт зориулан "УС БА ЭНХ ТАЙВАН" уриан дор зохион байгуулж буй "ДЭВЖЭЭ" тэмцээнд оролцох хүүхдүүдэд шаардлагатай материалын тооцоо

2024.03.27

| № | Хэрэглэгдэхүүний нэр | Нэг бүрийн үнэ | Тоо ширхэг | Нийт зардал |
|---|---|---|---|---|
| 1 | Жигдрэх хувцас | 60,000 | 10ш | 600,000 |
| 2 | 5 өнгийн хуулга | 3000 | 25м | 75,000 |
| 3 | Шүршдэг будаг | 10,000 | 5ш | 50,000 |
| 4 | Цэнхэр даавуу | 16,000 | 5м | 80,000 |
| 5 | Бүү | 50,000 | 3ш | 150,000 |
| 6 | Хадаг | 3000 | 6ш | 18,000 |
| | | | Нийт үнэ | 973,000 |

Тооцоо гаргасан: Сургуулийн нийгмийн ажилтан ....... /Ц.Анхтуяа/

**Худалдаа Хөгжлийн Банк** Огноо: **2024.03.28 15:06:01**

**Шилжүүлгийн мэдээлэл**
Журналын №: **152309618**

Системийн огноо: **2024.03.28**

Нэр: **БЛАСТ ХХК**

| | | | Дүн | Ханш |
|---|---|---|---|---|
| **Илгээгч** | Дансны дугаар: **463015533** | Нэр **БЛАСТ ХХК** | **973,000.00 MNT** | **1.00** |
| **/ есөн зуун далан гурван мянган төгрөг /** | | | | |
| **Хүлээн авагч** | Банкны дугаар: **90**<br>Дансны дугаар **100111615164** | Банкны нэр **Төрийн сан**<br>Нэр **Өм.Даланзадгад 5 сургууль-УТ** | **973,000.00 MNT** | **1.00** |

Гүйлгээний утга:
**ЕВ -Албан хүсэлтийн дагуу. Бласт ХХК**

**Танд баярлалаа**

**Гүйлгээний баримтыг баталгаажуулсан**
Салбар, тооцооны төв:
Гарын үсэг:

Тамга:

Огноо: Он Сар Өдөр

**БОМТ-ний хүрээнд гарсан зардал**

| № | **Баримт бичгийн нэр** | **Төсөвлөсөн төсөв/төгрөг** | **Төлөгдсөн мөнгөн дүн/төгрөг** |
|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал | 1’400’000 | 67’500’000 |
| **2** | Орчны тохижолт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 1,500,000 | 1.200.000 |
| 2 | Нөхөн сэргээлт | - | - |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | - | - |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө | - | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | - | - |
| 6 | Осол эрсдэлийн менежмент | 8’900’000 | 8’500’000 |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 2’000’000 | 2’117’000 |
| 8 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 27.500.000 | 27’870’000 |
| 9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 700’000 | 1’200’00 |
| 10 | **БОМТ-ний нийт зардал** | 42.000.000 | **108’887’000** |

# ХАВСРАЛТ БҮЛЭГ 12.

## 12.1. Тусгай зөвшөөрөл, баримт бичиг

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ**

**ЗӨВШӨӨРӨЛ**

Огноо: 2021-12-13 Дугаар: 0002031 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: Бласт ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9011125047
Регистрийн дугаар: 2688336
Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 1-р хороо, Чингэсийн өргөн чөлөө, "Пийс бридж" зочид буудал 203 тоот
Утас: 325995, 324044

**Дараах химийн хортой, аюултай бодис:** Импортлох, Худалдах, Ашиглах **аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг** 2021.12.13-2024.12.31 **хүртэл хугацаагаар олгов.**

| № | Бодисын нэр | | Томъёо | Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/ | Ангилал | Үйлдвэрлэсэн улс | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Монгол | Олон улсын | | | | | |
| 1 | Хавсралтад дурдсан 35 төрлийн бодис | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |

**Улсын хилээр нэвтрүүлэх боомт:** Замын үүд, ~~Буянт ухаа,~~ Сүхбаатар, Чингис хаан

**Зөвшөөрөл олгосон:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга / Д. ГАНБОЛД /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн / Ц.БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг Импортлох, Худалдах, Ашиглах 0002031 дугаартай тусгай зөвшөөрлийн хавсралт**

| № | Монгол нэр | Олон улсын нэршил | Томъёо | CAS дугаар | Зөвшөөрсөн хэмжээ, тн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Натрийн нитрат | Sodium nitrate | $NaNO_3$ | 7631-99-4 | 12 000 |
| 2 | Сульфокарбамид | Tiourea | $SC(NH_2)_2$ | 62-56-6 | 120 |
| 3 | Аммонийн нитратын талсжих цэг бууруулагч | Ammonium Nitrate Crystallization inhibitory | - | - | 180 |
| 4 | Натрийн нитрит | Sodium nitrite | $NaNO_2$ | 7632-00-0 | 300 |
| 5 | Нимбэгний хүчил | Citric acid | $C_6H_8O_7$ | 77-92-9 | 130 |
| 6 | Азотын хүчил | Nitric acid | $HNO_3$ | 7697-37-2 | 10 |
| 7 | Натрийн ацетат | Sodium acetate | $CH_3COONa$ | 127-09-3 | 120 |
| 8 | Цууны хүчил | Acetic acid | $CH_3COOH$ | 64-19-7 | 150 |
| 9 | Цайрын нитрат | Zinc nitrate hexahydrate | $Zn(NO_3)_2{\cdot}6H_2O$ | 10196-18-6 | 30 |
| 10 | Карбамид | Urea | $(NH_2)CO$ | 57-13-6 | 1100 |
| 11 | Натрийн додецил сульфат | Sodium dodecyl sulphate | $CH_3(CN_2)_{11}OS$ O3Na | 151-21-3 | 65 |
| 12 | Лаа,No | Composite wax, paraffine No | - | - | 200 |
| 13 | Лаа, NY-2 | Composite wax, paraffine NY-2 | - | | 900 |
| 14 | Лаа, HN | Composite wax, paraffine HN | - | - | 150 |
| 15 | Лаа, LF | Composite wax, paraffine LF | - | - | 125 |
| 16 | Лаа | Wax, paraffine | - | - | 200 |
| 17 | Бичил талстат лаа | Microcrystalline wax | - | 64742-60-5 | 200 |
| 18 | Урсах цэг бууруулагч T803B | Pour point depressant T803B | - | - | 30 |
| 19 | Эмульсжүүлэгч | Emulsifier | - | - | 2000 |
| 20 | Эмульсжүүлэгч PIBSA NB4745, | Emulsifier PIBSA,Polyisobutenyl succinnic anhydride, NB4745 | - | 67762-77-0 | 2000 |
| 21 | Эмульсжүүлэгч PIBSA NB2424, | Emulsifier PIBSA,Polyisobutenyl succinnic anhydride, NB2424 | - | 67762-77-0 | 2000 |
| 22 | Эмульсжүүлэгч LR-1 | Emulsifier, LR-1 | - | - | 150 |
| 23 | Эмульсжүүлэгч SMO, S-80 | Emulsifier /sorbitan monooleate/ SMO S-80 | $C_{24}H_{44}O_6$ | 1338-43-8 | 1500 |
| 24 | Хөнгөн цагаан | Aluminum | Al | 7429-90-5 | 100 |
| 25 | Фосфорын хүчил | Phosphoric acid | $H_3PO_4$ | 7664-38-2 | 150 |
| 26 | Этилгексил фосфорын хүчлийн нийлмэл эфир | Phosphoric acid, 2-ethylhexul ester | $C_8H_{17}O_4P_2$ | 12645-31-7 | 5 |
| 27 | Нийлмэл тосон фаз | Composite oil phase (Oil blend) | | | 9 000 |
| 28 | Аммонний тиоцианит | Ammonium tiocyanate | $NH_4SCN$ | 1762-95-4 | 15 |
| 29 | Шилэн бөмбөлөг | Glass (hollow) microsphere | - | - | 350 |
| 30 | Хуванцар бөмбөлөг | Plastic (polyethylene, polymer) microsphere, | - | - | 350 |
| 31 | Перлит сувдан давс | Perlite | - | 93763-70-3 | 200 |
| 32 | Калийн нитрат | Potassium nitrate | $KNO_3$ | 7757-97-1 | 12000 |
| 33 | Полиакриламид | Polyacrylamide | $(C_3H_5NO)_n$ | 9003-05-8 | 5 |
| 34 | Натрийн перхлорат | Sodium perchlotare | $NaClO_4$ | 7601-89-0 | 215 |
| 35 | Дизель түлш будагч | Fuel oil pigment | - | - | 2 |

15/XII

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

201 .9 оны .12 . сарын . 17 . өдөр Дугаар . .398 . . . Улаанбаатар хот

| | |
|---|---|
| *Эрхлэх үйл ажиллагааны төрөл* | Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэх |
| *Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр* | "БЛАСТ" ХХК |
| *Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг* | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Ландмарк оффис, 3 давхар |
| *Регистрийн дугаар* | 2688336 |
| *Тусгай зөвшөөрлийн хугацаа* | 3 /гурван жил/ |
| *Тусгай нөхцөл, шаардлага* | Холбогдох хууль, журам, дүрэмд заасан бүх шаардлагыг хангаж ажиллах |

*Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 201 . 9 оны . 12 . сарын . 17 . өдрийн А/242 дугаар тушаалыг үндэслэн олгов.*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД Д.СУМЪЯАБАЗАР

БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Ц. УРАНЧИМЭГ

ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Ө. МӨНХБАЯР

"БЛАСТ" ХХК-НИЙ "ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭРТ АШИГЛАГДАХ ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, АГУУЛАХ" -ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР:
6293956

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:
"ТӨГРӨГ БАЯН ХАНГАЙ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ЭРДЭНЭБАЯР

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"БЛАСТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.ТЭМҮҮЛИН

2023 ОН



**ХУДАЛДАА, НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШИЖ БУЙ ТАЛБАЙН ГАЗРЫН, БАЙДАЛ ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

**ЗАХИАЛАГЧ: “БЛАСТ” ХХК**

**ГҮЙЦЭТГЭСЭН : “АКРО МАНДАЛ” ХХК**

Хянан баталгааны төрөл: **Захиалгат**

Огноо: **2024.04.01**

Утас: +(976) 9611 7701
acromandal@gmail.com

**УЛААНБААТАР 2024 ОН**

## 12.2. ГЭРЭЭ

### БУТАЛСАН ЧУЛУУ ХАЙРГА БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Батлав.
"ЗУЛСОЁМБО"ХХК-ийн
Ерөнхий захирал:
БАТСАЙХАН

Батлав.
" БЛАСТ" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал:
А.ТЭМҮҮЛИН

2024 он 08 сарын 17-ны өдөр №ЦЦ/... Цогтцэций сум

Энэхүү "**Буталсан чулуу бэлтгэн нийлүүлэх гэрээ**" /цаашид "Гэрээ" гэх/-г нэг талаас Өмнөговь аймаг Цогтцэций сум, Өгөөмөр Бор-1, 102 тоот 501 тоот тоот хаягт орших, 3618501 тоот регистрийн дугаартай "**ЗУЛСОЁМБО**"ХХК /цаашид "Нийлүүлэгч" гэх/, нөгөө талаас Улаанбаатар хот СБД 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө ландмарк оффис 3 давхарт байрлах 2688336 тоот регистерийн дугаартай **БЛАСТ**" ХХК (цаашид" захиалагч" тал гэх) Монгол Улсын Иргэний хуулийг үндэслэл харилцан тохиролцож байгуулав.

Энэ гэрээнд талууд харилцан тэгш эрхтэй оролцсон бөгөөд гэрээний бүх зүйл заалттай бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөн болно.

**Нэг. Гэрээний нийтлэг үндэслэл нөхцөл**

1.1 **Гэрээний зорилго.** Энэхүү гэрээний зорилго нь Худалдагч нь Худалдан авагчийн хэрэгжүүлж буй ажилд шаардлагатай, хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасан холбогдох чанар, стандартын шаардлага хангасан, 10х20, 0,5 мм-ийн Хайрга (цаашид "Бараа материал" гэх)-г Худалдан авагчийн заасан хугацаанд нийлүүлэх, Худалдан авагч нь Бараа материалыг хүлээн авч, гэрээнд заасан үнийг төлөхтэй холбоотойгоор Талуудын хооронд үүсэх эрх үүрэг, хариуцлага, маргаан шийдвэрлэх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2 **Үйлчлэх хууль.** Энэхүү гэрээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тайлбарлаж, зохицуулна.

1.3 **Ажлын хүрээ.** Нийлүүлэгч энэхүү гэрээний дагуу гүйцэтгэх үүрэг нь дараах үндсэн чиглэлтэй байна.

БАТЛАВ. "ЗУЛСОЁМБО" ХХК
ЗАХИРАЛ
Н.БАТСАЙХАН

БАТЛАВ. "БЛАСТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ТЭМҮҮЛЭН

**БЕТОН ЗУУРМАГ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2024оны 02 сарын 21 -ний өдөр № 01/2024 Цогтцэций сум

**Нэг талаас:** "Зулсоёмбо" ХХК, түүнийг төлөөлж Бетон зуурмагийн үйлдвэрийн дарга албан тушаалтай Боргил овогтой Баатарчулуун /цаашид "Нийлүүлэгч" гэх/

**Хаяг:** Өмнөговь аймаг Цогтцэций сум, Өгөөмөр баг Бор 1-102 тоот
**РД:** 3618501
**И-мэйл:** Zulsoyombo9999@gmail.com
**Утас:** 8910 5102, 8888 6356

**Нөгөө талаас:**"Бласт " ХХК, түүнийг төлөөлж Салбарын дарга албан тушаалтай Д.Одхүү /цаашид "Захиалагч" гэх/

**Хаяг:** УБхот СБД 1-р хороо, чингисийн өргөн чөлөө ландмарк оффисын 3 давхарт
**РД:** 2688336
**И-мэйл хаяг:** info@blastcompany.mn
**Утас:** 9975 0550, 9907 4390

нар /цаашид "Талууд" гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож бетон зуурмаг нийлүүлэх болон насост машинаар бетон зуурмагийг цутгах ажлыг хийж гүйцэтгэхээр харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, стандартуудыг үндэслэн дараах нөхцлөөр энэхүү гэрээг 2024 оны 02 сарын 21 ний өдрөөс эхлэн 2024 оны 06 сарын 21 өдрийг хүртэл 4 сарын хугацаатай байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Иргэний хуулийн 243 дугаар зүйлд нийцүүлэн үүрэг хариуцлагатай холбогдон үүсэх болон бусад бүхий л харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энд заагдсан бүтээгдэхүүн гэдэг нь бетон зуурмаг ( **Read Mixed Concrete** )-ыг нэрлэсэн болно.

1.3. Нийлүүлэгч тал нь Захиалагч талын захиалгын дагуу бетон зуурмагийг техникийн нөхцөл, стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэн, тээвэрлэн нийлүүлж барилгын талбайд насост машинаар шахаж үйлчилнэ.

**Хоёр. Төлбөрийн нөхцөл**

2.1 **<u>Бетон зуурмагийн марк ба үнэ:</u>** Захиалагч тал дараах хүснэгт заасан бетон зуурмаг худалдан авна. Үнийн дүнд НӨАТ орсон болно. Үүнд:

| № | Бетон зуурмагийн | | | Х/н | Захиалгын хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | С ангилал | В ангилал | Марк | | | | | |
| | | | M300 | м.куб | 200 | 337,500 | 67,500,000 | 5 сард |
| | | | | | | | | |
| | | | Нийт | | 200 | | 67,500,000 | |

Хуудас 1 of 5

# 12.3. ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

MNAS Accreditation system
TL 08-10
MNS ISO/IEC 17025

Ус цаг уур орчны шинжилгээний төв
Байгаль орчны шинжилгээний
Лаборатори

Өмнөговь аймаг Даланзадгад сум 6-р баг
Утас/Факс: 70533648
E-mail хаяг umnugovi44373@gmail.com

ӨМНӨГОВЬ УЦУОШТ

**Захиалагч:** **“ Блас” ХХК**
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Цогтцэций сум Тэсрэх материалын агуулах
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Б.Янжин/ эрхлэгч
Сорьцын тоо хэмжээ: 4
Сорьцын төрөл: Орчны агаар
Сорьц авсан огноо: 2024.06.09
Лабораторид хүлээж авсан : 2024.06.10
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.06.10
Хэвлэсэн огноо: 2024.06.17
Хуудасны тоо: 1/1

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН/ мкг/м3**

| № | Хэмжилт хийсэн цэг | Хүхэрлэг хий/SO2 | Азотын давхар исэл NO2 | PM2.5 тоосонцор /20 минут | PM10 тоос/ 20 минут | Нийт тоос TSP 20 минут |
|---|---|---|---|---|---|---|
| | | Мкг/м3 | Мкг/м3 | Мкг/м3 | Мкг/м3 | Мкг/м3 |
| 1 | Оффис, уурын зуух орчим | 4 | 9 | 17 | 41 | 89 |
| 2 | Агуулах орчим | 7 | 12 | 17 | 23 | 91 |
| 3 | Харуулын орчим | 9 | 19 | 54 | 67 | 112 |
| 4 | Хогийн цэг | 3 | 7 | 21 | 49 | 63 |
| **Хүлцэх хэм хэмжээ MNS 4585: 2016** | | **450** | **200** | **50** | **100** | **500** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Техникч Х.Нармандах /Х.Нармандах /
(гарын үсэг) (нэр)

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч /Б.Янжин /
(гарын үсэг) (нэр)

ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ TL 08-10 УИТ0087

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лавлагаа Лабораторийн
ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

MNAS Accreditation system
TL 06-25
MNS ISO/IEC 17025

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ**

Өмнөговь аймаг Даланзадгад сум,6-р баг.
Утас: 7053-2960

## ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
## *CERTIFICATE OF ANALYSIS*

**Бүртгэлийн дугаар** */Registration number/* : 24-558
**Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр :** ӨМ:Цогтцэций сум Бласт ХХК
*/The name of customer's request for analysis/*
**Дэд лабораторийн нэр** */Name of the sub laboratory/* : Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори; Эрүүл ахуйн хими, хор судлалын хяналтын лаборатори

**Дээжийн тодорхойлолт** */Sample description/*

| Дээжийн дугаар *Sample number* | Дээжийн нэр *Name of sample* | Цувралын дугаар *Batch number* | Үйлдвэрлэсэн улс *The country of original manufacturer* | Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа *Date of expiry* | Дээжийн тоо хэмжээ *Quantity of the sample* |
|---|---|---|---|---|---|
| 2124 | Ахуйн хаягдал бохир ус | | Монгол Улс | Тодорхойгүй | 2.0 л |
| 2125 | Үйлдвэрийн ашиглалтын хаягдал бохир ус | | Монгол Улс | Тодорхойгүй | 2.0 л |

| Хүлээн авсан огноо *Date of receipt* | Шинжилгээ дууссан огноо *Date of test completion* | Хэвлэсэн огноо *Date of issue of the report* |
|---|---|---|
| 2024 он 07 сар 16 өдөр | 2024 он 07 сар 23 өдөр | 2024 он 07 сар 23 өдөр |

| Дээжийн дугаар *Sample number* | Шинжилгээний аргын стандарт *Method of analysis* | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж *Test parameter, unit* | Шаардлага *Test specification, unit* | Шинжилгээний дүн *Test results* |
|---|---|---|---|---|
| 2124 | MNS 5668:2006 | Эмгэгтөрөгч нян | 1 мл-т илрэхгүй | илрээгүй |
| | MNS ISO 5815-1:2015 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | 400мгO/л | 225.2мгO/л |
| | MNS ISO 10523:2001 | pH | 6-9 | 7.67 |
| | MNS ISO 11923:2001 | Умбуур бодис | 400мг/л | 157мг/л |
| | MNS ISO 9297:2005 | Хлорид | 1000мг/л | 74.43мг/л |
| 2125 | MNS 5668:2006 | Эмгэгтөрөгч нян | 1 мл-т илрэхгүй | илрээгүй |
| | MNS ISO 5815-1:2015 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | 400мгO/л | 220.5мгO/л |
| | MNS ISO 10523:2001 | pH | 6-9 | 6.49 |
| | MNS ISO 11923:2001 | Умбуур бодис | 400мг/л | 313мг/л |
| | MNS ISO 9297:2005 | Хлорид | 1000мг/л | 198.49мг/л |

**Санал тайлбар:**
*Opinions and interpretation*

**БАТАЛСАН:** ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: гарын үсэг/signature /Г .ЧИНЗОРИГ/
*Approved by*

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжид хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

MNAS Accreditation system
TL 08-10
MNS ISO/IEC 17025

Ус цаг уур орчны шинжилгээний төв
Байгаль орчны шинжилгээний
Лаборатори

Өмнөговь аймаг Даланзадгад сум 6-р баг
Утас/Факс: 70533648
E-mail хаяг umnugovi44373@gmail.com

ӨМНӨГОВЬ УЦУОШТ

**Захиалагч:** **"БЛАСТ" ХХК**

Сорьцын дугаар: 03-08
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Цогтцэций сум
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Б.Янжин
Сорьцын тоо хэмжээ: 4
Сорьцын төрөл: Хөрсний Агрохимийн шинжилгээ
Сорьц авсан огноо: 2024.06.09
Лабораторид хүлээж авсан : 2024.06.10
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.06.10
Хэвлэсэн огноо: 2024.06.17
Хуудасны тоо: 1/1

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| № | Үзүүлэлт | Шинжлэх аргын стандарт | Хэмжих нэгж | Шинжилгээний үр дүн | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Уурын зуух орчим | Агуулах | Харуулын байр | Хогийн цэг |
| 1 | Орчин-PH | MNS 3310:1991 | | 8.87 | 9.07 | 8.41 | 8.32 |
| 2 | Чийг | | % | 0.70 | 0.78 | 0.63 | 0.71 |
| 3 | Сульфат /SO4 | | Мг/кг | 54.1 | 221.4 | 156.8 | 751.6 |
| 4 | Нитрат /NO3 | | Мг/кг | 40.7 | 230.7 | 142.6 | 152.0 |
| 5 | Аммони /NH4 | | Мг/кг | 15.0 | 137.2 | 12.0 | 5.3 |
| 6 | ялзмаг | | % | 1.74 | 1.98 | 1.42 | 1.52 |
| 7 | Фосфор /$P_2O_5$ | | Мг/кг | 11.2 | 10.3 | 5.3 | 4.04 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Техникч Х.Нармандах /Х.Нармандах /
(гарын үсэг) (нэр)

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч /Б.Янжин /
(гарын үсэг) (нэр)

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 08-10 ҮИТ0087

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

**ХАНЛАБ ХХК**
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жавзандамба гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
http://www.khanlab.mn

## ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: **2024/1241**

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **БЛАСТ ХХК /ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ/**

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: **Хөрс, 4**

| № | ЛАБОРАТОРИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | ЭЛЕМЕНТ, % | | | | | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Na | Ca | Mg | K | $Fe_{нийт}$ | As | Ba* | Be | Bi | Cd |
| 1 | Л-11838 | Хогны цэг | Хөрс | 2.33 | 0.93 | 0.63 | 2.03 | 2.54 | 12.27 | 719.7 | 1.16 | <10.0 | <1.0 |
| 2 | Л-11839 | Урын зуух | Хөрс | 2.18 | 1.51 | 0.59 | 2.20 | 3.00 | 18.92 | 662.9 | 1.36 | <10.0 | <1.0 |
| 3 | Л-11840 | Тэсрэх материалын агуулах | Хөрс | 2.27 | 1.58 | 0.59 | 2.12 | 2.67 | 14.52 | 750.1 | 1.18 | <10.0 | <1.0 |
| 4 | Л-11841 | Үйлдвэр хаягдлын сан | Хөрс | 2.18 | 1.73 | 0.62 | 2.02 | 2.62 | 14.51 | 730.3 | 1.18 | <10.0 | <1.0 |
| | | *MNS5850:2019* | | - | - | - | - | - | *20.00* | - | - | - | *3.00* |

| № | ЛАБОРАТОРИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Co | Cr | Cu | La | Li | Mn | Mo | Ni | P | Pb |
| 1 | Л-11838 | Хогны цэг | Хөрс | 10.35 | 24.18 | 45.49 | 20.07 | 25.23 | 563.1 | <5.0 | 12.96 | 411.4 | 8.29 |
| 2 | Л-11839 | Урын зуух | Хөрс | 11.84 | 40.72 | 69.73 | 17.86 | 26.44 | 589.1 | <5.0 | 19.97 | 594.5 | 10.77 |
| 3 | Л-11840 | Тэсрэх материалын агуулах | Хөрс | 11.54 | 29.55 | 46.46 | 19.25 | 27.40 | 631.7 | <5.0 | 12.37 | 417.2 | 8.44 |
| 4 | Л-11841 | Үйлдвэр хаягдлын сан | Хөрс | 10.74 | 25.85 | 56.80 | 18.60 | 27.20 | 559.8 | <5.0 | 14.35 | 474.5 | 8.93 |
| | | *MNS5850:2019* | | *50.00* | *150.0* | *100.0* | - | - | - | *5.0* | *150.0* | - | *100.0* |

| № | ЛАБОРАТОРИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Sb | Se | Sr* | Ti | V | Y | Zn | Zr* | | |
| 1 | Л-11838 | Хогны цэг | Хөрс | <10.0 | <5.0 | 212.2 | 2816 | 63.79 | 10.38 | 59.21 | 81.57 | | |
| 2 | Л-11839 | Урын зуух | Хөрс | <10.0 | <5.0 | 211.4 | 2841 | 69.28 | 8.19 | 93.39 | 99.27 | | |
| 3 | Л-11840 | Тэсрэх материалын агуулах | Хөрс | <10.0 | <5.0 | 215.5 | 3007 | 70.96 | 10.01 | 67.48 | 98.21 | | |
| 4 | Л-11841 | Үйлдвэр хаягдлын сан | Хөрс | <10.0 | <5.0 | 221.2 | 2753 | 65.13 | 9.14 | 66.64 | 93.16 | | |
| | | *MNS5850:2019* | | - | *10.00* | *800.0* | - | *150.0* | - | *300.0* | - | | |

Чанарын менежер: Д. Пүрэвжаргал

**Тайлбар:** *-Бүрэн задрахгүй. /Хагас тоон утга/ Шинжилгээнд ирүүлсэн дээжийг 1 сар хүртэл хугацаагаар хадгална.

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна. Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: **2024.08.01**
ШИНЖИЛСЭН ОГНОО: **2024.08.12**

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: **хийгдсэн.**
ХУУДАСНЫ ТОО: 1

***Хамтран ажилласан танд талархлаа.***

Хуудас 1-1